



ОУХБ Япон улсын  
олон/хоёр талт хамтын  
ажиллаганы хөтөлбөр




Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага

# ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ

МАЛЧИН ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



УЛААНБААТАР 2016



ОУХБ Япон улсын  
олон/хоёр талт хамтын  
ажиллагааны хөтөлбөр



Олон Улсын  
Хөдөлмөрийн  
Байгууллага

# ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ

**МАЛЧИН ЗАЛУУЧУУДАД  
ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА**

Зохиогч: Я.Балгансүрэн, Д.Гүндэгмаа  
Хянан тохиолдуулсан: Ё.Нямдаваа

**УЛААНБААТАР 2016**

## ТАНИХ ТЭМДЭГ



Уншаарай



Бичээрэй



Сонсоорой



Хамтран ажиллаарай



Бодоорой



Ажиглаарай



Асуугаарай

## ОРОН НУТГИЙН БИЗНЕСИЙН ХАГЖИЛ

### Малчин залуучуудад зориулсан гарын авлага

Зохиогч: Я.Балгансүрэн, Д.Гүндэгмаа

Хянан тохиолдуулсан: Ё.Нямдаваа

Зураач: Г.Амарсанаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Д.Гүндэгмаа

## АГУУЛГА

1. Оршил .....	4
2. Бизнес .....	6
3. Зардал .....	15
4. Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ .....	21
5. Орлого .....	26
6. Ашиг .....	30
7. Санхүүгийн бүртгэл .....	35
8. Хуримтлал .....	39
9. Санхүүгийн төлөвлөгөө .....	44
10. Малчдын хоршоо .....	53
11. Хөгжих, дэвжих арга зам .....	58
12. Өөрийгөө үнэлэх асуулгын хариу .....	64

## НЭГ. ОРШИЛ

Энэхүү гарын авлагыг орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих сургалтын хүрээнд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын аргачлалаар боловсруулан суралцагч Танд хүргэж байна.

Малчин Таны өрхийн бизнесээс малчны хоршооны, хөдөө аж ахуйн дундын хоршооны бизнес цэцэглэн хөгжсөөр танай орон нутаг тэр чигээрээ амжилт, бүтээлээр дүүрэн байгаасай хэмээн билэгдэж бид гарын авлагаа **“Орон нутгийн бизнесийн хөгжил”** хэмээн нэрлэв.

Гарын авлагын **зорилго** нь малчдад бизнесийн анхан шатны мэдлэг, чадвар эзэмшүүлж, өрхийн аж ахуйгаа үр дүнтэй эрхлэн, орлого, ашгаа нэмэгдүүлэх, улмаар амьдралаа дээшлүүлэх арга ухаанаас суралцах эхний алхмаа хийхэд туслах явдал юм.

Гарын авлагын **агуулгыг** сонгохын өмнө суралцах бүлгийн төлөөллөөс хэрэгцээний судалгаа авч, тэдний өрхийн бизнесээ өргөжүүлэн хөгжүүлэхэд зайлшгүй чухал гэж үзсэн мэдлэг, чадварыг хамруулахыг хичээсэн болно.

“Бизнес”, “Зардал”, “Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ”, “Орлого”, “Ашиг”, “Санхүүгийн бүртгэл”, “Хуримтлал”, “Санхүүгийн төлөвлөгөө”, Малчны хоршоо”, “Хөгжих, дэвших арга зам” гэсэн 10 сэдвийн хүрээнд суралцагч Та дараах чадварыг эзэмших болно.

Үүнд:

- Бизнесийнхээ санааг шинжилж баталгаажуулах,
- Зардлыг бүртгэж тооцох,
- Түүхий эд, бүтээгдэхүүний үнийг тогтоох, үнийг үндэслэлгүй өсгөхөөс сэргийлэх,
- Түүхий эд, бүтээгдэхүүнээ ашигтай борлуулах,
- Орлого, ашгаа бүртгэж, тооцох,
- Санхүүгийн бүртгэл хөтлөх,
- Хуримтлал бий болгох, хуримтлалаа зөв зарцуулах,
- Малчдын хоршооны ач холбогдлыг зөв үнэлэх, бусадтай хамтран ажиллах,
- Бизнесийнхээ амжилтыг тогтвортой хадгалах, цаашид хөгжих, дэвших арга замаа зөв баримжаалах,
- Бизнесээ өргөжүүлж хөгжүүлэх гэх мэт.

Гарын авлагыг **бие дааж суралцах** гарын авлагын зарчмаар бичсэн ба сэдэв бүрийн эхэнд тухайн сэдвийг судлах явцад хэрэгжүүлэх суралцах үйлийн зорилго бий. Тэрхүү зорилгын дагуу Та уншиж судлах зүйлээ судлаад, малчин Ганаагийн гэр бүлийн түүх (жишээ)-тэй танилцана. Төгсгөлд нь үзсэн зүйлээ бататгах, өрхийнхөө зардал, орлого, ашгийг бүртгэж тооцох, санхүүгийн төлөвлөгөө боловсруулах, хоршооны гишүүдтэй ярилцах гэх мэт дасгал, даалгавар гүйцэтгэнэ.

Мэдсэн сурсан зүйлээ хэрхэн хэрэгжүүлэх талаар гэр бүл, найз нөхөд, малчны хоршоо, баг, сумын түвшинд ярилцах, санал хэлэх зэргээр хамтран ажиллана.

Сурсан зүйлээ Та **өөрөө үнэлнэ**. Өөрөө өөрийгөө үнэлэх юм уу гэж Та эргэлзэх хэрэггүй. Ер нь хүн “би энийг мэдэж, чадаж байна уу?” гэж өөрөөсөө асууж өөрөө

үнэлэх нь хамгийн шударга үнэлгээ шүү дээ. Таныг танаас илүү мэдэх, үнэн зөв үнэлэх хүн хаана ч байхгүй.

Бид "өөрийгөө үнэлэх" маш энгийн аргыг Танд зориулж боловсруулсан байгаа. Нэг сэдвийн дараа өөрийгөө үнэлэх хүснэгт бий. Хүснэгтэд буй өгүүлбэрүүдийг уншаад "тийм", "үгүй", "мэдэхгүй" гэсэн хариунаас өөрийнхөө хариултыг сонгон будна. Тэгээд номынхоо ард буй хариуны хүснэгтээс ямао сэдвийн хариу хэрэгтэй байгааг сонгон, өөрийнхөө хариулсан хүснэгтэй тулгаж үзээрэй.

Үнэлгээний хүснэгтийн ард үнэлгээний норм байгаа. Түүнийг хараарай. Тоймлон хэлбэл энэхүү гарын авлага нь ХЭРЭГЦЭЭ - ЗОРИЛГО - АГУУЛГА (сурах зүйл) - АРГА - ҮНЭЛГЭЭ гэсэн бүтэцтэй юм.

Бүтцийн нэгж бүрийн бүтцийг тодорхой нэг жишээгээр харуулъя.

ХЭРЭГЦЭЭ	Малчид өрхийн аж ахуйгаа үр ашигтай эрхлэхийн тулд бизнест суралцах хэрэгцээ шаардлага байна.
ЗОРИЛГО	Малчид бизнес эрхлэх, бизнестээ тохирох санхүү бүртгэлийн системийг сонгон хэрэглэх талаар мэдээлэл авч, чадвар эзэмших.
АГУУЛГА	Бизнес, санхүү бүртгэлийн анхан шатны мэдлэг, чадвар
АРГА	Бие даан сурах арга, санал солилцох ярилцлага, хэлэлцүүлэг, мэтгэлцээн
ҮНЭЛГЭЭ	Өөрийн үнэлгээ

Суралцагч Та энэхүү гарын авлагаар эзэмшсэн мэдлэг, чадвараа улам гүнзгийрүүлж гэвэл Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" хөтөлбөрийн сургалтад хамрагдан суралцаарай. Ер нь "Орон нутгийн бизнесийн хөгжил" хэмээх гарын авлагаар бие даан суралцах энэ сургалт нь "Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" сургалтын бэлтгэл шат гэж ойлгож болно шүү. Танд амжилт хүсье!

Зохиогчид

## ХОЁР. БИЗНЕС

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Бизнес, бизнесийн санаа, өрсөлдөөн, эрсдэл, зах зээлийн харилцааны итгэл итгэлцлийн талаар ойлголттой болно.
- Бизнесийн санаагаа хэрхэн сонгох дасгал, даалгавар хийнэ.
- Өөрийгөө үнэлнэ.

**Бизнес гэж юу вэ?**



Бизнес гэдэг нь бусдад хэрэгцээтэй бараа, түүхий эдийг нь нийлүүлэх замаар орлого, ашиг олж, улмаар санхүүгийн байдлаа сайжруулан, хуримтлал бий болгож байгааг хэлнэ.

Малчид өрхийн аж ахуйгаа хөтлөн авч явж байгаа нь бизнес эрхэлж буй хэрэг юм. Амжилттай бизнес нь хүмүүст хэрэгтэй, хүсч байгаа зүйлийг нь тохирсон үнээр борлуулаад, өөрөө хангалттай орлого олж, сайхан амьдрах боломж олгодог. Иймд та өөрийнхөө болон үйлчлүүлэгчийнхээ аль алиных нь сэтгэлд нийцсэн бизнесийн санаа олж хөгжүүлэх хэрэгтэй.

-Эмээлийн мод ямар үнэтэй вэ, хө?



-250 000 төгрөг

**Бизнесийн санаа хэр найдвартай болохыг яаж шалгах вэ?**

**а. Сонирхол, туршлагаа зөв үнэлнэ.** Суралцагч та бүхэнд бизнесийн ямар нэг санаа байгаа нь эргэлзээгүй. Гэхдээ Таны бизнесийн санаа хэр найдвартай болохыг дахин нэг шалгаарай. Үүний тулд Та эхлээд Ганаагийн гэр бүлийнхэн юу сонирхдог, ямар ажлын туршлагатай болохыг зургаас ажиглаарай.



Ганаагийнх



Дараах хүснэгтийг бөглөөд, Таны сонирхол, туршлага бизнесийнхээ санааг хэрэгжүүлэх түлхэц болох уу гэдгийг сайтар бодоорой.

Миний сонирхдог зүйл	Миний хамгийн сайн хийж чаддаг зүйл	Миний хийж чаддаг зүйлээс гэр бүл, найз нөхөд, бусад хүмүүс илүү үнэлдэг зүйл
1.	1.	1.
2.	2.	2.
3.	3.	3.
4.	4.	4.



## 6. Бизнес санааг сонгох шалгуур үзүүлэлтүүдийг мэдэж авна.




Дараах хүснэгтийг хэрхэн бөглөснийг уншаад, өөрийнхөө бизнесийн санааг харьцуулж үзээрэй.

Ур чадвар	Нөөц	Хэрэгцээ
1. Бэлчээр сонгох	1. Бэлчээр, ус, ургамал	1. Чанартай, эрүүл махны байнгын хэрэгцээ
2. Бэлчээрийн ургамлыг таних	2. Мал маллагааны уламжлалт арга	2. Цагаан сараар, хаварт махны өсөн нэмэгдэх хэрэгцээ
3. Малаа оторлох, таргалуулах	3. Мал маллагааны орчин үеийн арга	3. Уламжлалт мал маллагааны аргыг өвлөх, хөгжүүлэх гэх мэт
4. Хадлан, тэжээл бэлтгэх	4. Залуучуудыг мэргэшүүлэх сургалт	
5. Мах бэлтгэх	5. Өөрийн болон орон нутгийнхны мах борлуулдаг туршлага	
6. Мах борлуулах ...		



Дараах бүдүүвчийг ажиглаад, Таны болон танай багийн сонгохыг хүсч буй бизнес санаа хэр зэрэг найдвартай болох талаар эргэцүүлэн бодоорой.



**в. Бизнесийн санаагаа тусгай аргаар шинжлэх хэрэгтэй.**



**БИЗНЕСИЙН САНААГ ШИНЖЛЭХ АРГА:**

- Давуу тал (бизнесийн дотоод),
- Сул тал (бизнесийн дотоод),
- Боломж (бизнесийн гадаад),
- Аюул (бизнесийн гадаад).

**Давуу тал** гэдэг нь таны хүсч буй бизнесийн бусад ижил төстэй бизнесээс давуу талыг илэрхийлнэ. Жишээ нь: чанар, хийц, үнэ гэх мэт.

**Сул тал** нь таны болон бизнесийн чинь сул талыг илэрхийлнэ. Жишээ нь: ханган нийлүүлэгчдээс хол байвал таны бүтээгдэхүүний өртөг өндөр болно.

**Боломж** нь таны бизнест гаднаас нөлөөлөх хүчин зүйл юм. Жишээ нь, орон нутагт ирэх жуулчдын тоог бодлогоор нэмэгдүүлбэл Та гар урлалын бүтээгдэхүүн зардаг дэлгүүр ажиллуулах шийдвэр гаргаж болно.

**Аюул** нь таны ирээдүйн бизнест сөргөөр нөлөөлж, ашгийг тань бууруулах шалтгаан болно. Жишээ нь, Таны бизнес санаа маш нийтлэг бол олон хүн ижил бизнес эрхэлж таны зах зээлийг хумьж болно.

Давуу тал + боломж нь сул тал + аюулаас илүү бол эрсдэлээ тооцсоны үндсэн дээр та бизнес санаагаа хэрэгжүүлж болно.

Маш ноцтой зарим сул тал, аюул байна гэж үзвэл бизнесийн өөр санааг сонгох хэрэгтэй.




Адууны тоног хэрэгсэл хийж борлуулах жишээн дээр бизнесийнхээ санааны шинжилгээ хийгээд, гэр бүлийнхэнтэйгээ хэлэлцээрэй.

**Жишээ: Адууны тоног хэрэгсэл хийж борлуулах**

Давуу тал	Сул тал
- Борлуулах зах зээл ойр, иргэдээс захиалга авах боломжтой. - Хазаар ногт, эмээл тохом, чөдөр, ташуур хийхийг зааж өгөх туршлагатай хүн ойр байдаг. - Уяачид, иргэд жинхэнэ суран тоног хэрэгслийг их сонирхох болсон.	- Адууны тоног хэрэгсэл хийх туршлага бага.
Боломж	Аюул
- Адууны тоног хэрэгсэл хийдэг хүн орон нутагт ховор. - Наадам, баяр ёслолоор борлуулалт нэмэгдэнэ.	- Өрсөлдөгчид ижил төстэй бизнес эхэлж, борлуулалт буурч болно.

Шинжилгээг чиглүүлэх асуулт	Тийм	Үгүй
Давуу тал нь сул талаас илүү байна уу?		
Боломж нь аюулаас илүү байна уу?		
Сул тал, аюулыг би хэрхэн зохицуулах вэ?		



**Өрсөлдөхийн тулд адууны тоног хэрэгслийг маш сайн, чанар үзэмжтэй хийнэ.**  
**Адууны тоног хэрэгсэл хийх арга технологийг хурдан сурна.**



Бизнес эрхэлж, ашиг орлого олж, хуримтлал бий болгох зам нь дардан шулуун байдаггүй. Бизнес эрхлэх үед олон саад бэрхшээлтэй учирдаг нь хүсэхэд хясахын үлгэр мэт. Бизнес эрхлэх замд учрах хамгийн том саад бэрхшээлүүд гэвэл өрсөлдөөн болон эрсдэл юм.

### Өрсөлдөөн гэж юу вэ?



Зах зээлийн харилцаатай нийгэмд аж ахуй эрхлэн амьдарч байгаа хэн бүхэн өрсөлдөөнд орж байдаг. Малчин таны хувьд ч мөн адил.

Өрсөлдөөн бол зах зээлийн нийгмийн хөдөлгөгч хүч болдог буюу амьд байгальтай зүйрлэвэл, зах зээлд байгалийн шалгарлын үүргийг өрсөлдөөн гүйцэтгэдэг.

Зах зээлийн өрсөлдөөнийг амжилттай гэтлэх үндсэн зам нь өөрөө сурч хөгжих болон бусадтай хоршиж, хамтрах замаар өрсөлдөх чадвараа дээшлүүлэх явдал юм.

Өөрийгөө хөгжүүлэх ажил нь хоёр үндсэн чиглэлээр хийгдэнэ.

**Нэгдүгээрт**, хийж байгаа ажилтайгаа холбоотой ур чадварыг, тухайлбал, мал аж ахуй эрхэлж байгаа бол мал маллагаа, арчилгаа, малын гаралтай түүхий эдийн боловсруулалт, ашиг шим, бэлчээр, тэжээл зэрэгтэй холбоотой малчин хүний арга ухааныг эзэмших явдал чухал. Малчны арга ухаанд эцэг эх, ойр дотныхноосоо болон нутаг, нугынхаа туршлагатай малчдаас, өөрөөр хэлбэл, амьдрал дунд, орчноосоо суралцдаг уламжлалтай бөгөөд өнөө үед залуу малчдын сургалтад хамрагдах боломжтой боллоо.

**Хоёрдугаарт**, зах зээлийн нөхцөлд сайн малчин байх, малынхаа ашиг шимийг бүрэн ашиглаж бүтээгдэхүүн болгож чаддаг байх нь хангалтгүй тул дор дурдсан бизнесийн чадвар, дадлагыг эзэмших нь зүйтэй. Үүнд:

- Өрхийн аж ахуйгаасаа гарсан түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулах,
- Шаардлагатай зүйлээ үр ашигтай худалдан авах,
- Нөөцийн бүртгэл хөтлөх,
- Өртөг зардлаа тооцох,

- Орлого, зарлагаа бүртгэх, ашиг, хуримтлалаа тооцох,
- Ирээдүйн орлого, зарлагаа тооцож, төлөвлөх.

Эдгээр нь бидний хувьд бүтэхгүй, биелэхгүй зүйл биш юм. Үнэндээ өнөөгийн зах зээлийн харилцаат нийгэмд амьдарч буй бид эдгээр зүйлсийг өдөр тутмын амьдралдаа ашиглаж, хэрэглэж байдаг. Өрхийнхөө орлого, зарлага, одоо, ирээдүйг бодохгүй хэн байх вэ. Бидний гол алдаа гэвэл ихэнхдээ эдгээр зүйлсийн тухай бодоод л өнгөрдөг.

Харин “толгойдоо” бодоод өнгөрөх биш цаасан дээр бичиж буулган, түүнийгээ ажил, амьдралдаа ашиглаж сурах нь чухал юм. Өөрөөр хэлбэл, бидний шийдвэрүүд “оньсого таах”, “аз турших” байдлаар бус бодит баримт, мэдээнд тулгуурлан гарч, бид төлөвлөж, тооцоолсон, урьдчилж харсан үйл ажиллагаа явуулах ёстой. Ойлгомжтой болгох үүднээс, бид аливаа зүйлд ихэнхдээ хэрхэн ханддагаа санацгаая. Бид элдвийг хийхдээ юуны түрүүнд эмээл, хазаарлуугаа ухасхийдэг. Энэ нь “юу ч гэсэн мориндоо мордоё, тэгтэл нэг учир нь олдох байгаа” гэдэг дадлын маань илрэл юм. Энэ нь биднийг урьдчилан хараагүй нөхцөл байдал буюу **эрсдэлд** оруулдаг.



- Орлого зарлагаа тооцож, төлөвлөж байх хэрэгтэй л юм байна шүү дээ? Чи юуг нь бичдэг юм гээд л байсан...

- Одоо л суралцах гээд байна шүү дээ. Наана чинь “эрсдэл” гэж нэг юм яриад байна. Түүнийг мэдээд авъя.



### Эрсдэл гэж юу вэ?

Урьдчилан тооцоолоогүй шалтгаан, нөхцөл байдлаас хамааран бизнес хүссэн үр дүндээ хүрэхгүй, ашиг орлого нь буурах, алдагдал хүлээх нь эрсдэл юм.

### Эрсдэлд юу нөлөөх вэ?

- Байгаль, цаг уурын хүнд нөхцөл,
- Улс орны эдийн засгийн хүндрэл,
- Төр засаг, орон нутгийн засаг захиргааны оновчгүй бодлого,
- Өөрийн үйл ажиллагааны доголдол болон алдаатай шийдвэр ...



Байгаль, цаг уурын нөхцөл, бэлчээр, ус, отор нүүдэл, малын тарга хүч, эрүүл мэнд, ашиг шим, отор нүүдэл, хашаа хороо, хадлан тэжээл, малынхаа ашиг шимийг боловсруулах гээд үндсэн ажил, үйл ажиллагаатайгаа холбоотой эрсдэлээс хэрхэн сэрэмжлэх, эрсдэл тохиолдсон үед хэрхэн даван туулах арга ухааныг малчин хүн удам дамжин өвлөх буюу орчноосоо, хашир туршлагатай малчдаас сурдаг.

Харин өрхийн бизнесийнхээ эрсдлүүдийг хэрхэн зохицуулахыг орчноосоо сурах боломж маш хязгаарлагдмал, бараг боломжгүй байдаг. Учир нь, нэг талаас, малчин хүн түүхий эд бүтээгдэхүүнээ борлуулах арга замаа олох, зах зээлийн хэрэгцээ, нөхцлийг мэдрэх, зарах борлуулах үнээ тогтоох, гарах зардлаа болон орох орлого, олох ашигаа тус тус тооцоно. Энэ бүхнийг бүртгэж, тэмдэглэх, ирээдүйгээ төлөвлөх гэх мэт бизнес үйл ажиллагаа, тэдгээрийн явцад гарах шийдвэрийн зөв буруутай холбогдон гарах эрсдлүүдийн учир шалтгаан, үр дагавар, түүнээс сэргийлэх арга зам тоолж баршгүй олон байдаг. Нөгөө талаас, орон нутагт бизнесийн туршлага, дадлага чадвартай хүн ховор, бизнесийн орчин тогтворжоогүй, бизнесийн соёл нэвтрээгүй байдаг.



Бизнесийн сургалтад сууна аа, хө

Иймд, энэ төрлийн эрсдэлүүдээс хамгаалах үндсэн арга зам нь бизнесийн арга ухаанд суралцаж, улмаар эзэмшсэн мэдлэг, дадлага чадварууддаа тулгуурлан эрсдлийг урьдчилан харж, түүнээс сэргэмжлэх, хор уршгийг нь бууруулах чадвар эзэмших нь чухал юм. Өөрөөр хэлбэл, хэн ч танд эрсдэлээс бүрэн хамгаалах арга зааж өгч чадахгүй, зөвхөн та өөрийгөө хөгжүүлж суралцсанаар өөрийн мэдрэмж, мэдлэг, мэдээлэлдээ тулгуурлан эрсдэлээс хамгаалах буюу даван туулж чадах болно.



- Ноднин 2 жилийн дараа 2 дахин өсгөнө гээд хэдэн эм төлөг, борлон аваад яалаа? Ядаж өвөл гэж байдгийг бодох байсан юм...

- За за, өнгөрсөн юмыг яриад яахав. Одоо л алдахгүй байвал болоо биш үү?



### Зах зээлийн харилцаанд итгэл, итгэлцэл ямар үүрэгтэй вэ?

Зах зээлийн харилцаа гэдэг нь хүмүүсийн хоорондын зохистой харилцаа, тухайлбал, тэдний хоорондын харилцан итгэлцэл дээр үндэслэсэн харилцаа юм.

Бараа бүтээгдэхүүний борлуулалтын үед худалдан авах тал нь, барааны чанар, үзүүлэлтүүд хэрэгцээнд нийцэж байна гэсэн итгэлтэй болж байж, зарж борлуулж байгаа тал нь, танд өгч буй үнэ танд ашигтай, боломжтой гэж үзэж, итгэж байж бараа, мөнгөө солилцон, арилжаа хийдэг, өөрөөр хэлбэл, харилцан итгэлцсэн үед л арилжаа наймаа хийгддэг.

Банк, санхүүгийн байгууллагын зээл, нийлүүлэгчээс танд зээлээр олгож байгаа бараа, түүхий эдийн аль нь ч гэсэн танд итгэсэн итгэл, тодорхой хэлбэл, таныг эргүүлээд төлж чадна гэсэн тэдний итгэл дээр л үндэслэж олддог. Хэрэв танд итгэхгүй байгаа бол тэд зүгээр л өгөхгүй өнгөрнө.

Та ч гэсэн бусдад бүтээгдэхүүн, түүхий эдээ зээлээр өгөхдөө үнэ өртгийг нь эргүүлээд авч чадна гэсэн итгэл дээрээ л үндэслэж өгдөг.

Итгэлээ баталгаажуулахын тулд гэрээ байгуулах, барьцаа хөрөнгө тавих, алданги тооцох зэргийг ашигладаг.

Зээлээр борлуулалт хийх нь ихээхэн эрсдэлтэй алхам боловч эрсдэлгүйгээр хийх арга байдаг. Хэрэв та Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл" хөтөлбөрийн сургалтанд хамрагдаж суралцвал энэ дадлага чадварыг эзэмших болно.

Уг хөтөлбөрийн талаар болон сургалтанд нь хэрхэн хамрагдах боломжийн талаар энэ номын "Хөгжих, дэвжих арга зам" сэдвээс тодорхой мэдэж болно.



- Чи бид хоёр заримдаа хүнд зээлсэн юмаа авч чаддаггүй шүү дээ. Эрсдэлгүй зээлүүлэх аргыг хурдан мэдэж авах юмсан...

- Битгий яараад байл даа. Эхнээс нь дэс дарааллаар нь суръя л даа.



## Дүгнэлт

Зах зээлийн харилцаа бүхий нийгэмд аж ахуй эрхэлж буй хэн бүхэн, түүний дотор өрхийн аж ахуйгаа авч яваа малчин хүн бизнесийн тухай мэдлэг, чадвар, дадлагыг эзэмшиж, ашиглах ёстой.

Учир нь, зах зээлийн харилцааны өрсөлдөөнт орчинд, өрхийн аж ахуйгаа эрсдэл багатай, үр ашигтай, тогтвортой хөтлөн авч явахад тань бизнесийн тухай мэдлэг, чадвар, дадлага л Танд хэрэг болно.

**“Бизнес”** сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарсан өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай. Жишээг харна уу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Бусдад хэрэгцээтэй бараа, түүхий эдийг нь нийлүүлэн орлого, ашиг олох, санхүүгийн байдлаа сайжруулах, хуримтлал бий болгохыг бизнес гэнэ.			
2. Бизнесээс орлого, ашиг олж л байвал бусдын сэтгэл ханамж чухал биш.			
3. Ур чадвар, нөөц, хэрэгцээ бол бизнесийн санааг сонгох үндсэн шалгуур үзүүлэлт юм.			
4. Бизнесийн санааны найдвартай эсэхийг тогтоохын тулд тусгай аргаар шинжилгээ хийнэ.			
5. Бизнесийн санааны сул тал ба аюул нь илүү байвал түүнийг хэрэгжүүлж болно.			
6. Өрсөлдөөн бол зах зээлийн нийгмийн хөдөлгөгч хүч юм.			
7. Бизнес эрхлэхийн тулд заавал сургалтад суух шаардлагагүй.			
8. Нөөцийн бүртгэл хөтлөх, өртөг зардлаа тооцох, орлого, зарлагаа бүртгэх, ашиг, хуримтлалаа тооцох, ирээдүйн орлого, зарлагаа тооцож, төлөвлөх зэрэг бизнесийн чадвар, дадлыг эзэмшихийн тулд сургалтад хамрагдаж суралцах ёстой.			
9. Бизнесээ эхлэхийн тулд эхлээд “аз турших” хэрэгтэй. Бодож тооцож, цаг алдах хэрэггүй.			
10. Арилжаа наймаа нь худалдан авах тал болон борлуулах талын итгэл, харилцан итгэлцэл дээр явагдана.			
11. Би (манай гэр бүл) бизнесийн санаа олж, түүндээ шинжилгээ хийсэн.			
12. Бизнесээ амжилттай эрхлэхийн тулд сургалтад явахаар шийдсэн.			

Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариуны хүснэгт 1-тэй тулгаж үзээрэй.

## ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	<b>Хангалтай сайн</b>
2-3 зөрж байвал	<b>Хангалттай</b>
3-аас дээш зөрж байвал	<b>Сэдвээ дахин үзнэ үү</b>

## ГУРАВ. ЗАРДАЛ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Зардал, зардлын төрөл, зардлын бүртгэл, тооцооны талаар ойлголттой болно.
- Малчин Ганаагийнх өрхийнхөө нэг сарын зардлыг хэрхэн бүртгэж, тооцсон жишээтэй танилцана.
- Өнгөрсөн сарын өрхийнхөө зардлыг бүртгэж, тооцох дасгал хийж, өөрийгөө үнэлнэ.

**Зардал гэж юу вэ?**



Аливаа зүйлийг бий болгохтой холбогдон гарч байгаа мөнгөн зарлагыг зардал гэдэг.

Аж ахуй эрхлээд, борлуулалт хийж, орлого олохын тулд эхлээд мөнгөн зарлага гаргах хэрэгтэй болдог. Жишээлбэл, мах, сүү, арьс шир, ноос, ноолуурын алийг ч борлуулахын өмнө эхлээд мал худалдаж авах (хэрэв малтай бол энэ зардал мэдээж гарахгүй), өвс тэжээл авах, отор нүүдэл хийх, мал төллүүлэх, ашиг шимийг нь авах, боловсруулах, тээвэр хөлслөх, мал эмнэлгийн үйлчилгээ авах зэрэгт мөнгө зарах хэрэгтэй болно.



- Бизнес эрхлэхийн тулд эхлээд гарах зардлыг тооцох нь их чухал юм байна, тийм үү?

- Тэгэлгүй яахав. Яагаад гэвэл:

- Бүтээгдэхүүн, түүхий эдийнхээ зардлыг бууруулах, тогтвортой байлгах,
- Үнэ тогтоох,
- Эрсдэлгүй зөв шийдвэр гаргах,
- Ирээдүйн орлого, зарлагаа тооцож, санхүүгийн төлөвлөгөө боловсруулах үндэслэл болдог гэж байна, хө.



Малчин хүн өрхийн аж ахуйнхаа хүрээнд үр ашигтай бизнес эрхэлж, хуримтлал бий болгох, хуримтлалаа зөв зарцуулахыг л зорьж байдаг. Өөрөөр хэлбэл, бизнес эрхлэхийн үндсэн зорилго нь ашиг олох явдал юм. Ашгийг тоогоор илэрхийлье.



$$1\ 200\ 000 \text{ нийт ашиг} = 2\ 000\ 000 \text{ нийт орлого} - 800\ 000 \text{ нийт зардал}$$

Орлогоо ашиг гэж андуурах тал байдгийг анхаарна уу.



Нийт орлогыг борлуулалтын орлого, бусад орлого гэж 2 ангилж болно.

## Малчин өрхийн нийт орлого

### Борлуулалтын орлого

Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ (мах, арьс шир, өлөн гэдэс, ноос, ноолуур, сүү, цагаан идээ) борлуулж олсон мөнгө

### Бусад орлого

- Өрхийн аж ахуйгаасаа гадуур хийсэн ажлын хөлсөнд авсан мөнгө (өвс хадлан, түлээ түлш, гэрийн мод, бүрээс, тавилга, эмээл бэлтгэж зарах)
- зээл,
- тэтгэвэр, тэтгэмж, тэтгэлэг, хандив


Бизнесийн үндсэн зорилго болох ашиг (нийт ашиг = нийт орлого – нийт зардал) -ийг нэмэгдүүлэх 2 зам байна. Үүнд:

- нэгдүгээрт, орлогоо нэмэгдүүлэх,
- хоёрдугаарт, зардлаа бууруулах.

Зардлыг бууруулах тийм ч хялбар биш, тэр бүр боломжтой байдаггүй. Харин ашгийг нэмэгдүүлэх хамгийн боломжтой зам нь борлуулалтын болон бусад орлогоо нэмэгдүүлэх явдал юм.

### Зардлыг хэрхэн бүртгэж тооцох вэ?

Зардал гэж мөнгөн зарлагыг хэлнэ. Тэгэхээр өрхийн зардлыг бүртгэх гэдэг нь тухайн өрхөөс гарч байгаа бүх мөнгөн зарлагыг бүртгэнэ гэсэн үг болно.



Малчин айл мал, өвс тэжээл, тоноглол, түлш шатахуун, малын болон хүний эм тариа, хүнс, хувцас, ариун цэвэр, гоо сайхны бүтээгдэхүүн зэргийг худалдаж авах зорилгоор мөнгө зарлагдадаг.

Мөн хүн, малд эмнэлэгийн үйлчилгээ авсан, техник, тоног төхөөрөмжид засвар, үйлчилгээ хийлгэсэн, банкнаас зээл авсан, өөрсдөө болон үр хүүхдээ сургасан, бусдаар ажил хийлгүүлсний төлөө тус тус мөнгө төлдөг.

Ахиухан мөнгө хуримтлагдсан үед цахилгаан үүсгүүр, гэр ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар техник хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж худалдаж авахад мөнгөө зарцуулдаг. Ийм ихээхэн хэмжээний зардлыг **хөрөнгө оруулалтын зардал** гэдэг.

Малчин Ганаагийнх өнгөрсөн сард 4 төрлийн зардалд нийт **2 908 000** төгрөг зарцуулжээ. Үүнийг хэрхэн бүртгэж, тооцсоныг харна уу.



Мал аж ахуйн зардал Нутгийн чанар сайтай малтай айлаас төллөх насны 10 эм хонь, тус бүрийг нь 130 000 төгрөгөөр, түүнчлэн 100 боодол өвс, тус бүрийг нь 1200 төгрөгөөр, 20 уут хивэг, тус бүрийг нь 8000 төгрөгөөр, 60 литр бензин, литрийг нь 1800 төгрөгөөр, малыг шимэгчээс хамгаалах 2 ширхэг тариа, тус бүрийг нь 80 000 төгрөгөөр авчээ.

$$\text{Тухайн сарын Мал аж ахуйн нийт зардал} = \text{хонь худалдаж авсан зардал} + \text{өвс худалдаж авсан зардал} + \text{хивэг худалдаж авсан зардал} + \text{бензин худалдаж авсан зардал} + \text{эм, тариа худалдаж авсан зардал}$$

Энэ бүх тооцоог дараах хүснэгтийг ашиглан хийвэл хялбар байх болно.

Хүснэгт 2.1. Мал аж ахуйн зардлын тооцоо

Зардлын зориулалт	Хэмжих нэгж	Худалдаж авсан тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авсан үнэ (төгрөг)	Зардлын дүн (төгрөг)
Хонь худалдаж авах	тоо толгой	10	130 000	1 300 000
Өвс худалдаж авах	боодол	100	1 200	120 000
Хивэг худалдаж авах	шуудай	20	8 000	160 000
Бензин худалдаж авах	литр	60	1 800	108 000
Эм, тариа худалдаж авах	ширхэг	2	80 000	160 000
<b>Тухайн сард, мал аж ахуйтай холбоотой гарсан зардал</b>				<b>1 848 000</b>

Малчин өрх зөвхөн мал аж ахуйтайгаа холбоотой зардал гаргаад зогсохгүй амьдрал, ахуйтайгаа холбоотой олон төрлийн мөнгөн зарлага гаргадаг. Тэр бүх зардлыг ч дээрх хүснэгтийг ашиглан бүртгэж, тооцоолж болно. Жишээ нь:

Хүснэгт 2.2. Өрхийн хэрэгцээний зардлын тооцоо

Худалдаж авсан барааны нэр	Хэмжих нэгж	Худалдаж авсан тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авсан үнэ (төгрөг)	Зардлын дүн (төгрөг)
Гурил	килограмм	50	1 800	90 000
Цагаан будаа	килограмм	10	2 800	28 000
Элсэн чихэр	килограмм	3	2 000	6 000
Цай	боодол	2	5 000	10 000
Ургамлын тос	литр	1	4 000	4 000
Хүнсний ногоо	килограмм	10	1 500	15 000
Гар нүүрний саван	ширхэг	3	1 200	3 600
Эдийн саван	ширхэг	5	700	3 500
Угаалгын нунтаг	боодол	2	2 450	4 900
Шүдний оо	ширхэг	2	4 000	8 000
00-ийн цаас	боодол	5	800	4 000
Давс	килограмм	2	1 500	3 000
<b>Тухайн сард, өрхийн хэрэгцээнд гарсан нийт зардал</b>				<b>180 000</b>

Бусдаар хийлгэсэн ажил, нийгэм, соёл, боловсролын үйлчилгээ авсан зардлыг дээрх хүснэгтийг ашиглан бүртгэж, тооцож болно. Жишээ нь:

Хүснэгт 2.3. Ажил, үйлчилгээний хөлсөнд төлсөн зардлын тооцоо


Худалдаж авсан барааны нэр	Хэмжих нэгж	Худалдаж авсан тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авсан үнэ (төгрөг)	Зардлын дүн (төгрөг)
Нүүхэд тээвэр хөлслөсөн	явалт	2	30 000	60 000
Сургалтын төлбөрт	удаа	1	50 000	50 000
Сувилалын төлбөрт	хоног	10	30 000	300 000
Малд тарилга хийлгэсэн	тоо толгой	150	200	30 000
Сургуулийн арга хэмжээнд	удаа	1	40 000	40 000
<b>Тухайн сард ажил, үйлчилгээний хөлсөнд төлсөн зардал</b>				<b>480 000</b>

Хөрөнгө оруулалтын зардал гэж нэрлэдэг, өртөг өндөртэй зүйлс авсан бол мөн адил тооцож болно. Жишээ нь:

Хүснэгт 2.4. Хөрөнгө оруулалтын зардлын тооцоо

Худалдаж авсан барааны нэр	Хэмжих нэгж	Худалдаж авсан тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авсан үнэ (төгрөг)	Зардлын дүн (төгрөг)
Нарны зайн иж бүрдэл авсан	иж бүрдэл	1	400 000	400 000
<b>Тухайн сард хийсэн хөрөнгө оруулалтын зардал</b>				<b>400 000</b>

Ганаагийн гэр бүлийн тухайн сарын нийт зардлыг дараах байдлаар тооцно. Үүнд:



**1 848 000 ₮ + 180 000 ₮ + 480 000 ₮ + 400 000 ₮ = 2 908 000 ₮** боллоо. Үүнийг дараах байдлаар бичиж, тооцож байх нь цаашид ашиглахад ч хялбар, дөхөм байдаг.

Хүснэгт 2.5. Нийт зардлын дүн

Зардлын үзүүлэлт	Зардлын нийт дүн (төгрөг)
Мал аж ахуйн зардал	1 848 000
Өрхийн хэрэгцээний зардал	180 000
Ажил, үйлчилгээний хөлс	480 000
Хөрөнгө оруулалтын зардал	400 000
<b>Малчин өрхийн тухайн сарын нийт зардал</b>	<b>2 908 000</b>

Зардлыг ийнхүү бүртгэж, тооцоходоо тухайн хугацаанд гарсан бүх мөнгөн зарлагыг бүрэн хамруулахыг онцлон анхаарах хэрэгтэй.

Амьдрал дээр малчин хүн энэ бүртгэл тооцоог байнга хийж байдаг. Бичиж, тэмдэглэлгүй, зөвхөн “цээжиндээ” бодоод өнгөрдөг нь л алдаа болдог. Ингэснээр энэ бүртгэл тооцоог өөр бусад зорилгод ашиглах, улмаар ашиг орлогоо нэмэгдүүлэх хэрэгсэл болгох боломжоо алддаг.

Бүртгэж, тооцоолсон зардалд үндэслэн ашиг орлогоо хэрхэн яаж нэмэгдүүлж болдгийг бид номынхоо дараагийн хэсгүүдэд авч үзнэ.



Та өрхийнхөө өнгөрсөн сарын нийт зардлыг бүртгэж, тооцоолно уу. Үүний тулд, номынхоо энэ бүлгийг дахин анхааралтай уншиж, өмнөх жишээний хүснэгтийг ашиглаарай. Хийсэн бүртгэл, тооцоогоо хадгалаарай, бид түүнийг чинь дараа ашиглах болно.



Өрхийнхөө өнгөрсөн сарын зардлаа бүртгэж тооцоод, дүнг нь дараах зурагт байрлуулан бичээрэй.

Мал аж ахуйн зардал гэх мэт		
		Сарын нийт зардал .....

**“Зардал”** сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарсан өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай. Жишээг харна уу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Худалдан авалт, ажил үйлчилгээ, сургалт зэргийн үнэ, хөлсөнд төлж байгаа мөнгөн зарлагыг зардал гэнэ.			
2. Бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн зардлыг бууруулах, тогтвортой байлгахад зардлын бүртгэл тооцоо ач холбогдолтой.			
3. Бараа бүтээгдэхүүний үнийг тогтооход зардлын тооцоо хэрэггүй.			
4. Санхүүгийн төлөвлөгөөг зардлын бүртгэл тооцоонд үндэслэн боловсруулна.			
5. Бизнес эрхлээд олсон нийт орлого бол ашиг мөн.			
6. Малчин өрхийн нийт орлогыг борлуулалтын орлого, бусад орлого гэж 2 ангилж болно.			
7. Борлуулалтын болон бусад орлогоо нэмэгдүүлбэл ашиг нэмэгдэнэ.			
8. Өрхийн зардлыг бүртгэхдээ тухайн өрхөөс гарч байгаа гол гол мөнгөн зарлагыг бүртгэнэ гэсэн үг.			
9. Гэр ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар техник хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж, цахилгаан үүсгүүр худалдаж авахад зарцуулсан ихээхэн хэмжээний зардлыг хөрөнгө оруулалтын зардал гэдэг.			
10. Ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд зардлаа бүртгэж, тооцоод байх шаардлагагүй.			
11. Зардлаа бүртгэж тооцохгүй бол ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжоо алддаг.			
12. Манай гэр бүл өрхийн зардлаа бүртгэж тооцож байхаар шийдсэн.			

Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариуны Хүснэгт 2-той тулгаж үзээрэй.

## ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	<b>Хангалтай сайн</b>
2-3 зөрж байвал	<b>Хангалттай</b>
3-аас дээш зөрж байвал	<b>Сэдвээ дахин үзнэ үү</b>

## ДӨРӨВ. ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Үнэ, борлуулах ба худалдаж авсан үнэ, үнийг үндэслэлгүй өсгөхийн хор уршиг, үнийг үндэслэлтэй өсгөх арга зам, борлуулалтын багц, хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн бирж, нэмэгдсэн өртгийн тухай анхан шатны мэдлэгтэй болно.
- Түүхий эд, бүтээгдэхүүнийхээ борлуулалтын тооцоо хийж, үнийг нь үндэслэлтэй өсгөн зарах боломж байсан эсэх талаар дүгнэж ярилцах дасгал хийнэ.
- Өөрийгөө үнэлнэ.

**Үнэ гэж юу вэ?**



Үнэ гэдэг нь түүхий эд, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахын тулд төлсөн мөнгөн дүн юм.

Бизнес эрхлэгч бараа, бүтээгдэхүүнээ борлуулах үнийг тогтоохдоо тухайн барааг бий болгох, бүтээхэд зарцуулсан зардал дээр ашгаа нэмж тогтоодог.

**борлуулах үнэ = зардал + ашиг**

Гэвч манай орны тухайд нилээд онцлогтой. Мал аж ахуй эрхэлж, түүхий эд нийлүүлэн, бүтээгдэхүүнээ борлуулдаг өрхийн аж ахуй бүр тус тусдаа үнэ тогтоодоггүй. Харин мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зах зээлийн үнэ улирлын чанартай, нийтлэг байдлаар тогтсон байдаг. Иймээс малчин хүн зардал дээр ашгаа нэмж үнэ тогтоохоос илүү зах зээл дээр тогтсон **үнийн мэдээллийг** шуурхай авч, борлуулалт хийхдээ ашиглаж байх нь зөв юм.

Малын гаралтай түүхий эдийн үнийг өсгөх хэдэн үндсэн зам байдгийг малчин хүн мэдэж, ашиглаж байх ёстой.



- Малын гаралтай түүхий эдийн үнийг өсгөх ямар арга байдаг юм бол? Энийг л сурмаар юм байна, хө.

- Малын гаралтай аливаа түүхий эдийн үнэ улирлаар хэлбэлзэж байдаг.
- Түүхий эдийн үнэ түүний чанараас нь шууд хамаардаг.
- Түүхий эдийн чанар, үнэнд хадгалалт, тээвэрлэлт нөлөөлдөг.
- Борлуулж буй түүхий эдийн хэмжээ нэмэгдэх тусам үнэ нь өсөх хандлагатай байдаг гэж байна, хө...

**Борлуулалтын багц** гэдэг нь л их чухал юм шиг байна. Сонс доо. Би уншаадахъя.



## Үнийг үндэслэлтэй өсгөх арга зам

Аливаа худалдан авагчийн хувьд бараа, түүхий эдийг худалдан авахыг сонирхох доод хэмжээ байдаг. Үүнийг **борлуулалтын багц** гэж нэрлэе. Энэ нь тухайн бараа, түүхий эдийн хэрэгцээ, нэгжийн үнэ, тээвэр, хадгалалтын нөхцөл зэрэг олон зүйлээс шалтгаалдаг.

Борлуулалтын багц нь хонины ноосны хувьд нэг машин ноос, махны зориулалтаар худалдан авч буй малын хувьд нэг ачааны машины тэвш дүүргэх тооны мал буюу тонноор яригдах бол ямааны ноолуур, сарлагийн хөөвөр, ааруул, өрөм, жимсний хувьд килограммаар хэмжигдэнэ.

Борлуулалтын багцад хүрсэн хэмжээний түүхий эд, бүтээгдэхүүний нэгжийн үнэ хамгийн өндөр байдаг. Түүнээс гадна, тээвэрлэлт, борлуулалтын зардал хэмнэгддэг. Жишээ нь, өдөр бүр олон зуун литр сүү борлуулах боломжтой бол хэрэглэгч хүрч ирээд аваад байх магадлалтай, харин хэдхэн литр сүү бол өөрөө л хүргэж, борлуулах болдог.

Хөдөө орон нутгийн нөхцөлд борлуулалтын багцыг үүсгэх үндсэн арга зам нь **нэгдэж, хорших** явдал юм. Өнөөгийн нөхцөлд малчдын хоршооны нэг гол ач холбогдол бол мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулах илүү сайн боломжийг бүрдүүлэх явдал болж байна.

Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалттай холбоотойгоор малчид эвлэлдэж хорших хэрэгцээг үүсгэж буй өөр нэг шаардлага бол **түүхий эдийн бирж** юм.

Түүхий эдийн бирж нь зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, бодит үнэ тогтоох, ил тод байдлыг хангах, бизнесийн үйл ажиллагааны зардлыг бууруулах гэх зэрэг олон ач холбогдолтой.

Манай улсад бүрэлдэж бий болж байгаа хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржээр дамжуулан өрхийн аж ахуйнхаа түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулахын тулд хоршоонд элсэж, нэгдэх шаардлагатай болсон.

Зах зээлийн харилцааны гол хөдөлгөгч хүч нь өрсөлдөөн байдаг, өрсөлдөөнд амжилт гаргахын үндэс нь өрсөлдөх чадвар байдаг тухай "Бизнес" сэдэвт ярилцсан.

Хэрэв бид бүтээгдэхүүнийхээ үнийг хийсвэрээр өсгөвөл борлогдохгүй бөгөөд өрсөлдөх чадвар нь буурна. Жишээ нь, ноолуурынхаа үнийг үндэслэлгүй өсгөвөл борлогдохоо болино.

Учир нь ноолуур боловсруулж, бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэрүүд биднээс



үндэслэлгүй өсгөсөн үнээр ноолуур авбал зардал нь өсч бүтээгдэхүүнийх нь үнэ өснө. Тэгсэн тохиолдолд, биднээс 2 дахин их ноолуур самнаж авдаг хятадын ноолууран бүтээгдэхүүнд үнээрээ цохигдон бүтээгдэхүүн нь борлохгүй болно. Борлуулалт хийж чадаагүй үйлдвэр биднээс дахин ноолуур авч чадахгүй болж, бидний ноолуур борлохгүйд хүрнэ. Борлуулалтгүй учир бид өрсөлдөөнөөс хасагдаж, зах зээлээс шахагдана. Тэгэхээр үнийг үндэслэлтэй өсгөх зөв арга зам хэрэгтэй юм. Жишээлбэл, Сайн чанарын ноолуураа тусад нь ялган нийлүүлснээр ноолуурын үйлдвэр чанар сайтай, хэрэгцээ ихтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэн, өндөр үнээр борлуулж чадна. Чанартай ноолуурынхаа үнийг бид бусад ноолуурынхаас өндөр тогтоож болно. Ингэж үнийг нь үндэслэлтэй өсгөсөн ноолуур өрсөлдөх чадвараа хадгалж, борлогдоно.



- Чанар бол түүхий эд, бүтээгдэхүүний үнийг үндэслэлтэй өсгөх арга гэдэг нь ойлгомжтой байна. Борлуулалтын багц, биржийн худалдаа хоёрыг л ойлгохгүй байна даа...

Бид **борлуулалтын багц** бүрдүүлсэн тохиолдолд худалдан авч байгаа талын тухайн зүйлийг цуглуулах тээврийн зардал, хүн хүч хэмнэгдэх учир тэд бидэнд төлөх үнээ өсгөдөг байна.

**Бирж нь** түүхий эдийн чанарын ялгалт, хяналт хийж, борлуулалт, худалдан авалтыг багцалж, арилжааг үнэ хаялцуулсан өрсөлдөөнт байдлаар явуулдаг, үйлдвэрлэгч, нийлүүлэгч хоёрыг зуучлагч, завсрын дамжлагагүйгээр шууд уулзуулдаг. Тэгэхээр нэгж бүтээгдэхүүний үнэ үндэслэлтэй өсөх боломж байгаа биз дээ?



- Манайх ер нь хоршоонд элсвэл яасан юм бэ? Биржээр дамжуулж ноос, ноолуураа үнэтэй борлуулъя л даа...

- Элсэх гээд л судлаад байна шүү дээ. Үйлдвэрлэгч, нийлүүлэгч хоёрын хооронд зуучлагч, завсрын дамжлагагүй гэдэг нь л чухал байна.



Зах зээлд гарч буй аливаа бүтээгдэхүүн **худалдаж авсан үнэ, борлуулах үнэ** гэсэн хоёр үнэтэй байдаг. Бусдад бүтээгдэхүүнээ худалдах үнийг борлуулах үнэ, бусдаас худалдан авсан үнийг худалдаж авсан үнэ гэдэг нь Танд ойлгомжтой байгаа байх аа.

Малчдын борлуулах бүтээгдэхүүн нь худалдаж авсан байхаасаа илүү өрхийн аж ахуйн хүрээнд өсч, үржиж, бий болсон байдаг. Энэ тохиолдолд, уг бүтээгдэхүүнийг бий болгоход зарцуулагдсан зардлыг худалдаж авсан үнэнд тооцож болно.

Борлуулах үнэнээс худалдаж авсан үнийг хассан зөрөөг **нэмэгдсэн өртөг** гэж нэрлэдэг.

**нэмэгдсэн өртөг = борлуулах үнэ – худалдаж авсан үнэ**



Үнийг ингэж ангилах нь ашиг, орлогодоо санхүүгийн задлан шинжилгээ хийхэд тохиромжтой байдаг.

Санхүүгийн задлан шинжилгээ болон түүнийг хэрхэн хийдэг, ямар ач холбогдолтойг "Бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл" хөтөлбөрт суралцсанаар мэдэж авч болно.



Цэгийн оронд нөхөж бичээрэй.

**ҮНЭ**

.....

.....



Зөв холбож зураарай.

Үнийг үндэслэлтэй өсгөвөл

Өрсөлдөөнөөс хасагдаж, зах зээлээс шахагдана.

Үнийг үндэслэлгүй өсгөвөл

Өрсөлдөх чадвараа хадгалж, илүү ашиг олно.



Та өрхийнхөө өнгөрсөн жилийн бүтээгдэхүүнүүдийг ямар үнээр, хэрхэн борлуулснаа жагсаан бичнэ үү.

Борлуулсан барааны нэр	Хэмжих нэгж	Борлуулсан тоо хэмжээ	Нэгжийг борлуулсан үнэ (төгрөг)	Хаана хэрхэн борлуулсан



Үнэ өсгөх арга замуудыг ашиглаж, бүтээгдэхүүн тус бүрийнхээ борлуулалтын онцлогийг тооцон үзэх замаар өнгөрсөн жилийнхээ борлуулсан бүтээгдэхүүнийхээ үнийг өсгөн худалдаалах боломж байсан эсэхийг дүгнэж ярилцаарай.

Хэрэв танд дасгалуудыг хийх явцад ойлгомжгүй, хүндрэлтэй зүйл гарвал энэ номын ард товч бүртгэл нь байгаа багш нартай холбоо барьж зөвлөгөө аваарай. Гарсан дүгнэлт, үр дүнгээ хадгалаарай, бид дараа ашиглах болно.

**“Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ”** сэдвийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарсан өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Худалдан авалт, ажил үйлчилгээ, сургалт зэргийн үнэ, хөлсөнд төлж байгаа мөнгөн зарлагыг зардал гэнэ.			
2. Зардал + ашиг нь худалдан авсан үнэ болно.			
3. Бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах нь зардлыг нэмэгдүүлж үнийг бууруулна.			
4. Борлуулалтын багцад хүрсэн хэмжээний түүхий эд, бүтээгдэхүүний нэгжийн үнэ хамгийн өндөр байдаг.			
5. Борлуулалтын багц бүрдүүлснээр тээвэрлэлт, борлуулалтын зардал нэмэгддэг.			
6. Малчдын хоршоонд элсвэл мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулах илүү сайн боломжийг бүрдүүлнэ.			
7. Түүхий эдийн бирж нь зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, бодит үнэ тогтоох, ил тод байдлыг хангах, бизнесийн үйл ажиллагааны зардлыг бууруулах гэх зэрэг олон ач холбогдолтой.			
8. Бусдад бүтээгдэхүүнээ худалдах үнийг борлуулах үнэ, бусдаас худалдан авсан үнийг худалдаж авсан үнэ гэдэг.			
9. Түүхий эд, бүтээгдэхүүний үнийг үндэслэлтэй өсгөвөл, өрсөлдөөнөөс хасагдаж, зах зээлээс шахагдана.			
10. Түүхий эд, бүтээгдэхүүний үнийг үндэслэлтэй өсгөвөл, өрсөлдөх чадвараа хадгалж, илүү ашиг олно.			
11. Борлуулах үнэнээс худалдаж авсан үнийг хассан зөрөөг нэмэгдсэн өртөг гэж нэрлэдэг.			
12. Манай гэр бүл малчдын хоршоонд элсэхгүй. Ямар ч ашиггүй гэсэн.			

Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариуны Хүснэгт 3-тай тулгаж үзээрэй.

## ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	<b>Хангалтай сайн</b>
2-3 зөрж байвал	<b>Хангалттай</b>
3-аас дээш зөрж байвал	<b>Сэдвээ дахин үзнэ үү</b>

## ТАВ. ОРЛОГО

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Орлого, түүний бүрдэл хэсгийн талаар ойлголттой болно.
- Малчин Ганаагийн гэр бүл нэг сарын орлогоо хэрхэн бүртгэж, тооцсон жишээтэй танилцана.
- Ганаагийн орлогын тооцооны жишээн дээр бодож дүгнэх, өөрийнхөө өрхийн өнгөрсөн сарын орлогын тооцоог хийх дасгал хийнэ.

### Орлого гэж юу вэ?



Орлого гэдэг нь бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх буюу нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанаас тухайн хугацаанд олсон мөнгөн хөрөнгө юм.


Орлогыг борлуулалтын орлого, бусад орлого гэж 2 хуваадаг.

Борлуулалтын орлогыг дотор нь мал аж ахуйн борлуулалтын орлого, мал аж ахуйн бус борлуулалтын орлого гэж хувааж болох юм.



- За хө, юун олон орлого вэ? Чи зураад тайлбарлаад өгөөч...

- За тэгье. Хоёулаа хамт зуръя. Орлого гэж нэг юм байна. Нэг дөрвөлжин дүрсээр тэмдэглэе. Тэр нь 2 төрлийн байж болох нь. Хоёр салаалаад хоёр дөрвөлжин зуръя...



Эхлээд мал аж ахуйн гаралтай борлуулалтын орлогыг хэрхэн тооцоолохыг авч үзье. Нэг төрлийн мал, бүтээгдэхүүн, түүхий эдийнхээ борлуулалтын орлогыг бид дараах байдлаар тооцоолж чадна.

**Борлуулалтын орлого = тоо x үнэ** Энд, тоо гэдэг нь бусдад борлуулсан, тухайн төрлийн мал, бүтээгдэхүүн, түүхий эдийн тоо хэмжээ, үнэ гэдэг нь тухайн зүйлийг борлуулсан үнэ болно. Борлуулалтын нийн орлогоо олохын тулд мал, бүтээгдэхүүн, түүхий эдийнхээ борлуулалтын орлогуудыг нэмж гаргана.

Малчин Ганаагийнх өнгөрсөн сард нийт **3 230 000** төгрөгний орлого олжээ. Үүнээс борлуулалтын орлого **2 830 000** төгрөг, бусад орлого **400 000** төгрөг байв. Үүнийг хэрхэн тооцоолсныг харна уу.



Мал аж ахуйн гаралтай борлуулалтын орлого Энэ сард 15 хонь тус бүрийг 120 000 төгрөгөөр, 10 килограмм ноолуурыг, килограммыг нь 70 000 төгрөгөөр, 2 нэхий тус бүрийг 10 000 төгрөгөөр, 300 литр сүүг, литрийг нь 500 төгрөгөөр тус тус борлуулжээ.

Одоо тухайн сарын мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг тооцоолж гаргавал:

$$\text{Мал аж ахуйн борлуулалтын орлого} = \text{хонь борлуулсан орлого} + \text{ноолуур борлуулсан орлого} + \text{нэхий борлуулсан орлого} + \text{сүү борлуулсан орлого}$$

буюу, уг өрхийн тухайн сарын мал аж ахуйн борлуулалтын орлого нь:

$$1\ 800\ 000\ ₮ + 500\ 000\ ₮ + 20\ 000\ ₮ + 150\ 000\ ₮ = 2\ 470\ 000\ ₮ \text{ болно.}$$

Энэ бүхнийг дараах хүснэгтийг ашиглан бичиж, тооцоолж болно.

Хүснэгт 5.1. Мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүн борлуулалтын тооцоо

Борлуулсан мал, бүтээгдэхүүн, түүхий эд	Хэмжих нэгж	Борлуулсан тоо хэмжээ	Нэгжийг борлуулсан үнэ (төг)	Зардлын дүн (төг)
хонь	тоо толгой	15	120 000	1 800 000
ноолуур	килограмм	10	50 000	500 000
нэхий	ширхэг	2	10 000	20 000
сүү	литр	300	500	150 000
<b>Мал аж ахуйн борлуулалтын орлого</b>				<b>2 470 000</b>

Хүснэгт 5.2. Мал аж ахуйн бус түүхий эд, бүтээгдэхүүн борлуулалтын тооцоо

Борлуулсан зүйлс	Хэмжих нэгж	Борлуулсан тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Орлогын дүн (төг)
Чөдөр, ногт	хос	4	40 000	160 000
Жимс	литр	50	4 000	200 000
<b>Мал аж ахуйн бус борлуулалтын орлого</b>				<b>360 000</b>

Хүснэгт 5.3. Өрхийн тухайн сарын борлуулалтын нийт орлого

Борлуулалтын орлогын төрөл	Борлуулалтын орлогын дүн (төг)
Мал аж ахуйн борлуулалтын орлого	2 470 000
Мал аж ахуйн бус борлуулалтын орлого	360 000
<b>Өрхийн тухайн сарын борлуулалтын нийт орлого</b>	<b>2 830 000</b>

Хүснэгт 5.4. Тухайн сард орсон бусад орлогын тооцоо

Орлогын эх үүсвэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ (төг)	Орлогын дүн (төг)
Айлын хашаа, хороо сэлбэж, засалцсан ажлын хөлс	хоног	4	20 000	80 000
Хүүхдийн мөнгө	хүүхэд	3	20 000	60 000
Ээжийн тэтгэвэр	удаа	1	260 000	260 000
<b>Бусад орлогын дүн</b>				<b>400 000</b>

Борлуулалтын орлого, бусад орлогын нийт дүн нь нийлээд өрхийн тухайн сарын нийт орлого болно.

**Нийт орлого = борлуулалтын нийт орлого + бусад орлогын дүн**

Хүснэгт 5.5. Өрхийн тухайн сарын нийт орлогын дүн

Орлогын төрөл	Орлогын дүн
Борлуулалтын нийт орлого	2 830 000
Бусад орлогын дүн	400 000
<b>Өрхийн тухайн сарын нийт орлого</b>	<b>3 230 000</b>



Бодоод хариулаарай.

- Ганаагийн гэр бүлийн хэддүгээр сарын орлогын тооцоо вэ?
- Малчид ноолуураа голдуу хэддүгээр сард зардаг вэ?
- Малчдын сар бүрийн орлого тогтмол ижил хэмжээтэй байдаг уу?
- Малчид аль улиралд, хэддүгээр сард илүү орлоготой байдаг вэ?
- Ямар улиралд бага орлоготой, их зарлагатай байдаг вэ?
- Өвөл мал аж ахуйтай холбоотой гарах зардлаа Та хэзээнээс хуримтлуулдаг вэ?
- Малчин хүн "Намар үрээ суулгаад, хавар ургацаа хурааж авдаг" гэдэгтэй Та санал нийлэх үү?



Ганаагийн нэг сарын өрхийн орлогыг дараах зургаас ажиглаарай. Ямар төрлийн орлого бага, аль нь дунд зэрэг, аль нь хамгийн их байна вэ?




- Таны бодлоор Ганаагийнх сар бүр жигд орлоготой байхын тулд ямар төрлийн орлогоо нэмэгдүүлэх хэрэгтэй вэ?



Өрхийнхөө өнгөрсөн сарын нийт орлогыг бүртгэж, тооцоолоорой.

а. Тооцоолохын тулд эхлээд дараах бүдүүвчид орлогоо жагсаан бичээрэй.



б. "Орлого" сэдвийн хүснэгт(5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5)-ыг ашиглан тооцоогоо хийгээрэй.



Хийсэн бүртгэл, тооцоогоо хадгалаад, багш болон бусад хүмүүст үзүүлж зөвлөгөө аваарай. Таны хийсэн орлогын тооцоо "Орлого" сэдвийг хэр зэрэг ойлгосны чинь үнэлгээ болно.

## ЗУРГАА. АШИГ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Ашиг, ашгийн бүртгэл, ашгийн тоон утга, ашиг алдагдлыг зохицуулах арга замын талаар ойлголттой болно.
- Малчин Ганаагийн гэр бүл нэг сарын ашгаа хэрхэн бүртгэж, тооцсон жишээтэй танилцана.
- Орлого, ашгийн талаар үзсэн зүйлээ бататгах, өрхийнхөө өнгөрсөн сарын ашгийг тооцоолох дасгал хийнэ.

### Ашиг гэж юу вэ?



Олсон орлогоос гаргасан зардлаа хассаныг ашиг гэдэг. Бизнес эрхлэхийн үндсэн зорилго нь ашиг юм.

**нийт ашиг = нийт орлого - нийт зардал**

Нийт орлого, зардлыг тус бүрт нь хэрхэн тооцоолохыг өмнө үзсэн. Жишээ нь, Ганаагийн өрхийн нийт орлого нь 3 230 000 төгрөг байсан, харин нийт зардал 2 908 000 төгрөг байсан. Эндээс ашгийг нь олбол:

**3 230 000 ₮ - 2 908 000 ₮ = 322 000 ₮** нь ашиг болно.

Малчин айл ашгийн бүртгэлээ дараах байдлаар хөтөлж хэвших нь олон талын ач холбогдолтой.

Санхүүгийн үзүүлэлтийн нэр	Санхүүгийн үзүүлэлтийн тоон утга
Мал аж ахуйн борлуулалтын орлого	2 470 000
Мал аж ахуйн бус борлуулалтын орлого	360 000
Бусад орлого	400 000
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>3 230 000</b>
Мал аж ахуйн зардал	1 848 000
Өрхийн хэрэгцээний зардал	180 000
Ажил, үйлчилгээнд төлсөн хөлс	480 000
Хөрөнгө оруулалтын зардал	400 000
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>2 908 000</b>
<b>АШИГ</b>	<b>322 000</b>



- Энэ чинь чи бид хоёрын өмнө нь хийгээд байсан тооцооны дүнгүүд байна шүү дээ...

- Тэгэлгүй яахав. Орлого, зарлагын тооцооноос л ашгаа бодно шүү дээ.



Ашгийн тоон утга нэмэх буюу хасах тэмдэгтэй гарч болно. Нэмэх тэмдэгтэй гарвал ашигтай байгааг, хасах тэмдэгтэй гарвал алдагдалтай байсныг тус тус харуулна. Өөрөөр хэлбэл, тухайн сарын нийт орлого нь нийт зарлагаа нөхөж чадсан, зарлагаа нөхөөд илүү гарсан, нөхөж чадаагүй дутсан гэдгийг харуулж байгаа хэрэг юм.

Аль нэг сард алдагдалтай гарах нь тэр бүр түгшээд байх шалтгаан биш. Хамгийн чухал нь малчин өрх бүтэн жилийн дүнгээр л ашигтай ажилласан байх ёстой.

Тухайн сард алдагдалтай гарах нь олон төрлийн учир шалтгаантай байж болно. Тухайлбал, тэр сард хөрөнгө оруулалтын томоохон зардал гаргасан эсвэл үржлийн мал олон тоогоор худалдаж авсан зэргээс алдагдалтай гарсан байж болох талтай. Эдгээр тохиолдолд тайван байж болно.

Алдагдалтай гарах нь мал аж ахуйн бизнес улирлын чанартай борлуулалтын орлого жилийн сар, улирал бүрт жигд бус байдагтай холбоотой байж болно.



*Сайхан эд байна шүү...*

Хавар, зун ноолуур, ноос, сүү цагаан идээнээс, мал таргалсан үед намрын турш болон өвлийн эхний хагаст мал махнаас малчдын орлого олох боломж нэмэгддэг.

Харин өвлийн төгсгөл, хаврын эхний хагаст малчдын орлогын боломж эрс буурдаг. Гэтэл зөрөөд сар шинийн баяр, сульдаж доройтсон малаа тэжээж тэнхрүүлэх, мал төллөх гэх мэтээс хамаарч өрхийн хэрэгцээний болон мал аж ахуйн зардал өсдөг. Эдгээрээс шалтгаалан өвлийн сүүлч болон хаврын эхэн саруудад малчин өрхийн аж ахуй мэдээж алдагдалтай гарна.

Ашигтай гарсан саруудад бий болсон хуримтлалаа алдагдалтай саруудад зөв зохистой зарцуулах замаар нэмэлт зардал гаргахгүй давахыг зорих хэрэгтэй. Жишээ нь, хавар самнасан ноолуураа бүгдийг нь тухайн үед борлуулаад, зарцуулаад дуусгалгүй, харин томоохон зардлууд гарах үед борлуулж ашиглахаар заримыг авч үлдэж болох юм. Ашиг, алдагдлаа зохицуулахын тулд санхүүгийн төлөвлөлт хийж сурах шаардлагатай.

Ашгаа бүртгэх нь олон талын ач холбогдолтойн нэг нь ашиг, алдагдалдаа дүгнэлт хийх, үйл ажиллагаандаа үнэлгээ өгөх, зөв шийдвэр гаргах зэрэгт бодитой үндэслэл болдог явдал юм.

Ганаагийн өрхийн тухайн сарын ашигт дүгнэлт хийж үзье. Тэднийх тухайн сард ашигтай гарсан. Өрхийн тухайн сарын ашиг нь **322 000** төгрөг байсан. Энэхүү ашиг хуримтлал болж үлдэнэ. Хуримтлалын тухай асуудлыг бид номынхоо "Хуримтлал" сэдэвт үзнэ.

Энэ айлаас тухайн сард гарч байгаа зардлуудыг анхааралтай харвал, амьдрал ахуйн зайлшгүй хэрэгцээг хангах зардлууд, мал аж ахуйн үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхэд чиглэсэн зардлууд, эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий зардлууд, амьдралын чанараа дээшлүүлэхэд чиглэсэн зардалууд тус тус байна. Эдгээрээс хэмнэх, бууруулах боломж муу юм.



Ийм учраас өрхийн тухайн сарын ашгийг нэмэгдүүлэх үндсэн арга зам нь борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх явдал болж байна.

### **Борлуулалтын орлогоо яаж нэмэгдүүлэх вэ?**

Борлуулалтын орлого нь:

**борлуулалтын орлого = борлуулсан тоо хэмжээ x борлуулсан үнэ**

Эндээс харахад, тоо хэмжээ, үнийн аль нь ч өссөн борлуулалтын орлого нэмэгдэхээр байна. Гэвч борлуулах үнээ үндэслэлгүй өсгөх нь өрсөлдөх чадварыг бууруулдаг тухай бид "Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ" хэсэгт, ноолуурын жишээн дээр ярилцсан.

Тэгэхээр борлуулсан тоо хэмжээгээ нэмэгдүүлэх боломжийг хайх ёстой нь тодорхой харагдаж байна.



- Би борлуулалтынхаа орлогыг нэмэх арга оллоо...

- Яаж нэмэгдүүдэх нь вэ? Ном үзээд манай өвгөн чинь бүр "цоорч" эхлэв, бололтой...



- Өнгөрсөн сарын орлогын ихэнхийг бүрдүүлж байсан **борлуулах хонины тоог** ирэх жил **нэмэгдүүлэх,**

- Сүүнийхээ борлуулалтаа нэмэгдүүлэхийн тулд айл саахалттайгаа нийлж **борлуулалтын багц бүрдүүлэх** (Борлуулалтын багцын тухай "Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ" сэдэвт байгаа шүү дээ),

- **Хүнсний ногоо тарьж** орлогоо нэмэх арга зам байна.

- Олон хонь зарах юм байна. Айлуудтай нийлээд их сүү бэлтгэж зарах юм байна. Бас ногоо тарих нь. Болох юм биш үү? Би дэмжиж байна аа, хө.

- Энэ жил манайх 15 хонь 120 000-аар зараад 1 800 000 төгрөгний орлого олсон. Ирэх жил 25-30 хонь зармаар байна.

Борлуулалт, зардал, ашгийн бүртгэл хөтлөх нь ашгаа эргэж харж дүгнэх, өнгөрсөн үйл ажиллагаандаа үнэлгээ дүгнэлт өгөх, ирээдүйнхээ талаар үндэслэлтэй бодох боломж олгодгийг бид Ганаагийн гэр бүлийн жишээн дээр харлаа.



а. Орлого, ашиг хоёр ямар ялгаатайг ярилцаарай. Ярилцахдаа доор бичсэнийг ашиглаарай.

**борлуулалтын орлого = тоо хэмжээ x үнэ**

**нийт ашиг = нийт орлого - нийт зардал**

б. Ганаагийнх хавар самнасан ноолуураа бүгдийг нь тухайн үед борлуулаад, зарцуулаад дуусгалгүй, харин томоохон зардлууд гарах үед борлуулж ашиглахаар заримыг авч үлдсэн байна. Энэ ямар зорилготой байсан бэ?



Дараах асуултуудад хариулаарай.

- Ашгийн тоон утга **нэмэх** тэмдэгтэй тоо гарч байвал Та юу гэж ойлгох вэ?
- Ашгийн тоон утга **хасах** тэмдэгтэй тоо гарч байвал Та юу гэж ойлгох вэ?
- Нэмэх тэмдэгтэй тоог өмнө нь ямар ч тэмдэггүй, хасах тэмдэгтэй тоог өмнө нь хасах тэмдэгтэй -1500, -200, -8850 гэх мэт бичдэгийг Та мэдэх үү?
- Ганаагийн ашгийг 322000 гэж бичсэн байна, Та юу гэж ойлгож байна вэ?
- Өөр нэг айлын ашиг - 240 000 гэж гарсан байна, Та юу гэж ойлгож байна вэ?



Өрхийнхөө өнгөрсөн сарын ашгийг бүртгэж, тооцоолоорой. Үүний тулд урьд нь хийсэн зардал, орлогынхоо тооцоог ашиглаарай.

а. Юуны өмнө орлого ба зардлынхаа дүнгийн хүснэгтийг ол.

*Өнгөрсөн сарын нийт орлогын дүн*

Орлогын төрөл	Орлогын дүн
<b>Өрхийн тухайн сарын нийт орлого</b>	

*Өнгөрсөн сарын нийт зардлын дүн*

Зардлын үзүүлэлт	Зардлын нийт дүн (төгрөг)
<b>Малчин өрхийн тухайн сарын нийт зардал</b>	

б. **Нийт ашиг = Нийт орлого - нийт зардал** гэдгийг санаарай. Хийсэн бүртгэл, тооцоогоо хадгалаарай, Танд дараа дахин хэрэг болно.

**“Орлого”, “Ашиг”** сэдвүүдийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарсан өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Борлуулсан тоо, хэмжээг борлуусан үнээр үржүүлсэнийг борлуулалтын орлого гэнэ.			
2. Нийт орлого дээр нийт зардлаа нэмсэнийг ашиг гэнэ.			
3. Орлогыг борлуулалтын орлого, бусад орлого гэж 2 ангилдаг.			
4. Борлуулах түүхий эд, бүтээгдэхүүний тоо, хэмжээг нэмэгдүүлбэл орлого буурна.			
5. Борлуулах зүйлийнхээ тоо, хэмжээг нэмэгдүүлбэл орлого нэмэгдэнэ.			
6. Ашгийн тоон утга хасах тэмдэгтэй тоо гарвал ашигтай байна гэсэн үг.			
7. Ашгийн тоон утга нэмэх тэмдэгтэй тоо гарвал ашигтай байна гэсэн үг.			
8. Борлуулалтын багц бүрдүүлснээр ашиг нэмэгдэхгүй, харин ч зардал нэмэгдэнэ.			
9. Малчин өрхийн орлого улирлын чанартай жилийн сар, улирал бүрт жигд бус байдаг.			
10. Ашиг, алдагдлаа зохицуулах гэж илүү ажил болсоны хэрэггүй. Олсон хэдийгээ хэзээ, яаж зарцуулах нь угаасаа тодорхой юм чинь.			
11. Ашиг, алдагдлаа бодож зохицуулах хэрэгтэй. Орлого багатай саруудад алдагдал хүлээхгүй байхад бэлэн байх ёстой.			
12. Манай гэр бүл орлого, зардал, ашгаа бүртгэж, тооцоолж байхаар шийдсэн.			

Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариуны Хүснэгт 4-тэй тулгаж үзээрэй.

## ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	<b>Хангалтай сайн</b>
2-3 зөрж байвал	<b>Хангалттай</b>
3-аас дээш зөрж байвал	<b>Сэдвээ дахин үзнэ үү</b>

## ДОЛОО. САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Санхүүгийн бүртгэл, гүйлгээ, санхүүгийн бүртгэл хөтлөхөд анхаарах зүйлийн талаар ойлголттой болно.
- Малчин Ганаагийн гэр бүлийн наймдугаар сарын санхүүгийн бүртгэлийн жишээтэй танилцана.
- Үзсэн зүйлээ бататгах, өрхийнхөө өнгөрсөн сарын санхүүгийн бүртгэлийг хөтлөх дасгал хийнэ.

### Санхүүгийн бүртгэлд юуг бүртгэдэг вэ?



Санхүүгийн бүртгэлд мөнгөн гүйлгээг бүртгэдэг. Аливаа бараа, түүхий эд, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг мөнгөөр солихыг гүйлгээ гэж нэрлэдэг.

Малчин өрх зардал гаргаж, мөнгө төлж байгаа, мөн орлого олж, мөнгө авч байгаа тохиолдол бүр нь гүйлгээ хийж байгаа хэрэг юм. Жишээ нь:

- мал борлуулж мөнгө авах,
- дэлгүүрээс бараа авч мөнгө төлөх,
- туслах малчинд цалин өгч мөнгө төлөх,
- сүү зарж мөнгө авах зэрэг нь бүгд гүйлгээ юм.

Санхүүгийн бүртгэлд гүйлгээ бүрийг тус тусад нь нэг мөрөнд бичих ёстой.



- Юу вэ? Дахиад л бүртгэл, тооцоо юу? ...

- Үгүй дээ. Өмнө хийсэн бүртгэл тооцоон дээрээ үндэслээд хийх илүү амархан арга зааж өгье гэж байна.



Бизнес амжилттай, ашигтай байхын үндэс нь санхүүгийн төлөвлөлтийг бодитой, үндэслэлтэй хийж, орлого, зардал, ашгаа зөв бүртгэж, тооцох явдал юм.

Бид өмнө нь орлого, зардал, ашгийг тус тусад нь бүртгэж, тооцоолох тухай үзэж, мэдлэгээ хэрэглэх дасгал хийсэн. Энэ нь санхүүгийн бүртгэл хөтөлж сурах алхмууд юм. Орлого, зардал, ашгийг байнга тус тусад нь хөтлөнө гэвэл хүндрэлтэй, хэрэгжүүлэхэд бэрх ажил болно. Харин **санхүүгийн бүртгэл** хөтөлсөнөөр бүртгэл тооцоог ихэд хялбарчлах боломжтой.

Санхүүгийн бүртгэлийг олон хэлбэр, загвар, маягтаар хийж болох боловч малчин өрхийн тухайд санхүүгийн бүртгэл нь их энгийн хялбар байх нь зохимжтой байдаг.

Одоо Ганаагийнх 8 дугаар сарын санхүүгийн бүртгэлээ хөтөлсөнийг харъя.

Хүснэгт 7.1. Наймдугаар сарын санхүүгийн бүртгэл (төгрөг)

Сар/өдөр	Гүйлээний утга	Мал аж ахуйн орлого	Мал аж ахуйн бус орлого	Бусад орлого	Мал аж ахуйн зардал	Өрхийн хэрэглээний зардал	Ажил, үйлчилгээнд төлсөн хөлс	Хөрөнгө оруулалтын зардал
1	2	3	4	5	6	7	8	9
8/03	ноолуур	500 000						
8/03	тэтгэвэр авсан			260 000				
8/03	малд тарилга хийлгэсэн						30 000	
8/03	бензин худалдаж авсан				54 000			
8/03	эм тариа худалдаж авсан				160 000			
8/03	гурил					90 000		
8/03	гар нүүрний саван					3 600		
8/03	барааны саван					3 500		
8/03	угаалгын нунтаг					4 900		
8/03	шүдний оо					8 000		
8/03	00-ийн цаас					4 000		
8/03	давс					3 000		
8/08	сүү	50 000						
8/10	хонь	1 800 000						
8/12	чөдөр, ногт хийж зарсан		160 000					
8/12	сургалтын төлбөрт						50 000	
8/15	сүү	50 000						
8/16	бензин худалдаж авсан			60 000	54 000			
8/16	хүүхдийн мөнгө авсан							
8/16	цагаан будаа					28 000		
8/16	элсэн чихэр					6 000		
8/16	цай					10 000		
8/16	ургамлын тос					4 000		
8/16	хүнсний ногоо					15 000		

1	2	3	4	5	6	7	8	9
8/17	хивэг худалдаж авсан				160 000			
8/20	сувилалын төлбөрт						300 000	
8/24	хороо сэлбэсний хөлс			80 000				
8/25	нэхий	20 000						
8/25	сүү	50 000						
8/25	сургуулийн арга хэмжээнд						40 000	
8/26	нүүхэд тээвэр хөлслөсөн						60 000	
8/28	түүсэн жимсээ худалдсан		200 000					
8/28	өвс худалдаж авсан				120 000			
8/29	хонь худалдаж авсан				1 300 000			
8/30	нарны зайн систем авсан							400 000
<b>Орлого, зардал тус бүрийн дүн</b>		<b>2 470 000</b>	<b>360 000</b>	<b>400 000</b>	<b>1 848 000</b>	<b>180 000</b>	<b>480 000</b>	<b>400 000</b>
<b>Нийт орлого, нийт зардлын дүн</b>		<b>3 230 000</b>			<b>2 908 000</b>			
<b>Ашиг</b>		<b>322 000</b>						

Санхүүгийн бүртгэлийн онцлог ба давуу талыг нягталж харцгаая.

- Бидний өмнө хийж байсан бүртгэлүүдээс ялгаатай нь гүйлгээ хийсэн **сар, өдрийг тодорхой заасан** байна. Ер нь санхүүгийн бүртгэл, тайлан тооцоонд гүйлгээ хийсэн он, сар, өдөр чухал ач холбогдолтой байдаг. Учир нь санхүүгийн аливаа тайлан тооцоо, тэдгээрт үндэслэн хийх дүгнэлт, гарах шийдвэрүүд цаг хугацаатай нягт уялдаатай байдаг.
- Мөн өмнө нь бидний олон хүснэгт ашиглан гаргаж авч байсан мэдээлэл, үр дүнг ганц энэ хүснэгтээс гарган авч байна. Тухайлбал, багануудыг дүгнээд орлого, зардлын дүнг ангилал тус бүрээр нь гарган авч болж байна. Мэдээж, тэдгээрийг нэмж нэгтгэх замаар нийт орлого, нийт зардал тус бүрдээ бодогдоно. Нийт орлогоосоо нийт зардлыг хасвал өрхийн 8 дугаар сард олсон ашиг гарна. Өмнө нь 9 ширхэг тус тусдаа хүснэгт ашиглан хөтөлж, тооцоолж байсан зүйлсийг бид нэг хүснэгтэнд багтаан бүртгэж, тооцоолоо. Санхүүгийн бүртгэл хөтөлөхийн ач холбогдол, давуу тал нь энэ юм.

## Санхүүгийн бүртгэл хөтлөхөд гол анхаарах зүйл нь юу вэ?

- Гүйлгээний бичилтийг хийхдээ анхааралтай, хянамгай байх,
- гүйлгээний нэр, хугацааг тодорхой бичих,
- хамгийн гол нь гүйлгээний тоон утга буюу мөнгөний тоог харгалзах багананд зөв бичихэд анхаарна.

Бичилтүүдийг алдаагүй зөв хийсэн тохиолдолд, борлуулалтын нийт орлого, нийт зардал, ашгийг тооцоолоод гаргаж ирэх боломж бүрдэнэ. Тооцоо хийхдээ тооны машин ашиглаж хэвших хэрэгтэй.



- Санхүүгийн бүртгэл чинь харин зүгээр юм байна. Сарын эхнээс орлого, зардлаа бүртгэж яваад, сарын эцэст дүгнэчих юм байна, хө.



- Харин тийм байна. Нэг дэвтэр гаргаад санхүүгийн бүртгэлийн хүснэгтийг хийгээд өгье. Чи хөтөлж байгаарай. Өрхийн нягтлан бодогч боллоо шүү. Харамлахыг нь л эхлээд сураад авав даа!



- Аливаа бараа, түүхий эд, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг мөнгөөр солихыг юу гэж нэрлэдэг вэ?
- Туслах малчинд цалин өгөх гүйлгээ мөн үү?
- Сүү зарах гүйлгээ мөн үү?
- Санхүүгийн бүртгэлд юуг бичих вэ?
- Санхүүгийн бүртгэлд яагаад заавал он, сар, өдрийг бичих ёстой вэ?
- Санхүүгийн бүртгэл хөтлөхдөө юуг анхаарах вэ?
- Санхүүгийн бүртгэл хөтлөхийн ач холбогдол, давуу тал нь юу вэ?



Та өрхийнхөө өнгөрсөн сарын санхүүгийн бүртгэлийг хөтөлнө үү. Үүний тулд "Зардал", "Орлого", "Ашиг" сэдвүүдийг үзэж байхдаа хийсэн бүртгэл, тооцоогоо ашиглаарай.

Өнгөрсөн сарын санхүүгийн бүртгэлээ хийсэн бол, өнгөрсөн жилийнхийгээ хийж, бүтэн жилийн орлого, зардал, ашгийнхаа тооцоог хийж үзээрэй.

Хэрэв танд ойлгомжгүй, хүндрэлтэй зүйл гарвал багш нарт хандаарай.

Хийсэн бүртгэл, тооцоогоо хадгалаарай, тэдгээрийг бид дараа дахин ашиглах болно.



-Болороо хоёулаа юу сурснаа дүгнэе. Чи юу сурснаа эхнээс нь хэлээд бай. Би цаасан дээр бичээд, наагаад байя.

- Бизнесийн санаагаа шинжлэх

- Зардлыг бүртгэж, тооцоолох

- Түүхий эд, бүтээгдэхүүний үнийг тогтоох

- Орлогыг бүртгэж, тооцоолох

- Ашгаа тооцоолох

- Санхүүгийн бүртгэл хөтлөх

- Тооцох, харьцуулах арга

## НАЙМ. ХУРИМТЛАЛ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Хуримтлал, түүний ач холбогдол, хуримтлалыг бий болгох арга замын талаар ойлголттой болно.
- Малчин Ганаагийн гэр бүлийн хуримтлалын төлөвлөгөөтэй танилцана.
- Өрхийнхөө хуримтлалын төлөвлөгөөг хийх ялдамд үзсэн зүйлээ бататгах, дасгал хийнэ.

**Хуримтлал гэж юу вэ?**



Ашиг олох нь хуримтлал бий болгох боломжийг бүрдүүлнэ. Өөрөөр хэлбэл, аж ахуйн зардал, өрхийн хэрэглээнээс илүү гарсан орлогоо хуримтлуулж, цаашид үр ашигтай зарцуулах боломж бий болно.

**Хуримтлал** бол Танд бусад хөрөнгөнөөс чинь илүү давуу тал, боломж олгодог онцгой хөрөнгө юм. Үүнийг одоо тайлбарлая.

Мал, хашаа саравч, гэр, тавилга, техник хэрэгсэл, машин, трактор, мотоцикл болон хувцас, хүнсний нөөц, өрхийн хэрэгцээний мөнгө нь таны өмч, хөрөнгө бөгөөд өөр өөрийн тодорхой зориулалттай байдаг. Тэдгээрийг өөр зориулалтаар ашиглах, өөрчилж солих боломж хязгаарлагдмал байдаг.

Харин хуримтлуулсан мөнгийг ямар ч зориулалтаар, юунд ч ашиглаж болох боломжтой, чөлөөтэй байдаг онцлогтой.

Хуримтлалыг үр ашигтай зарцуулах нь малчин өрхөд өсч дэвжихийн үндэс суурь, аливаа эрсдэлээс хамгаалах хаалт бамбай болж өгдөг.



Түм нэгээс эхэлдэг



## Хуримтлалыг юунд зарцуулж болох вэ?

Малчин өрх нь ашиг олж, хуримтлуулсан мөнгөө дараах зүйлд зарцуулах боломжтой. Үүнд:

- мал худалдаж авч, орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэхэд,
- техник, тоног төхөөрөмж худалдан авч, бүтээмжээ дээшлүүлэхэд,
- шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах боломж бүрдүүлэхэд,
- түүхий эдээ боловсруулах, анхан шатны тордолт хийх зэргээр үнэ ханшийг нь өсгөх, өртөг нэмж шингээх нөхцөл бий болгоход,
- байгаль цаг уурын хүнд нөхцөлд эрсдэлээс хамгаалах, сэргийлэхэд,
- үр хүүхдээ сургаж, мэргэжил, боловсрол эзэмшүүлэхэд,
- шаардлагатай тохиолдолд эмчилгээ, сувилгааны зардалд тус тус зарцуулж болно.

## Яаж хуримтлалтай болох вэ?

1. **Тодорхой зорилго** тавих хэрэгтэй. Зорилго нь хэмжиж болохоор, тодорхой байна.

2. **Тодорхой хугацаа** товлох хэрэгтэй. “Хоёр жилийн дотор машин авна” гэх мэт.

3. Хуримтлуулахаар зорьсон мөнгөө **долоо хоног, сард хуваа**. Түүнийгээ ягштал баримталж долоо хоног эсвэл сард хураах ёстой мөнгөө заавал хураа.

4. **Зардлын бүртгэл тооцоогоо** сайн хөтлөөд багасгаж, хэмнэж болох зардлыг ол.

5. Банкинд **хүүтэй хадгаламжийн** данс нээлгэ.

6. **Урьдчилж тооцоогүй орлогыг** шууд хадгал. Хэн нэгнээс бэлгэнд авсан мөнгө, мөнгөн шагнал гэх мэт.



Ганаагийнх төллөх насны 10 эм хонь худалдаж авахаар болов. Тэгвэл ирэх хавар энэ жилийнхээс 10-аар илүү буюу 25 хонь зарж, ашгаа нэмэгдүүлэх боломжтой болно. Хуримтлал ч нэмэгдэнэ. Худалдаж авсан 10 хонь хургалвал, зарсан хонио ч нөхнө. Дараагийн жил дахиад хургална.

Гэхдээ 10 хонины үнэ 1 300 000 төгрөг. Их мөнгө. 300 000-ыг нь энэ жилийн ашиг 322 000 төгрөгөөс хуримтлуулах болов. Харин 1 000 000 төгрөг хуримтлуулах хэрэгтэй байдаг... Ганаа, Болороо хоёр хонь худалдаж авах мөнгө цуглуулахаар хуримтлалын төлөвлөгөө боловсруулав.



- 1 000 000 төгрөг хуримтлуулах л хэрэгтэй. Өнгөрсөн сард манайх 500 литр сүү, долоо хоногт 125 литр, хоногт 17-18 литр сүү зарсан. худалдах сүүнийхээ хэмжээг нэмж болж байна. Бас цагаан идээ...



- Би хэдэн сайхан чөдөр, ногт зангидна. Болно доо, болно. Болдоо хашаа засалцаад, пин барилцаад өгөөрэй гэсэн...

Ганаагийн гэр бүлийн хуримтлалын төлөвлөгөө		
Хуримтлалын зорилго	Төллөх насны 10 эм хонь худалдаж авах	Тооцоо
<b>Зорилгын өртөг</b>	1 000 000 төгрөг	
1 сарын дотор хуримтлуулна гэвэл долоо хоногт хэдэн төгрөг хуримтлуулах шаардлагатай вэ?	250 000 төгрөг	$1\ 000\ 000 \div 4$ долоо хоног
2 сарын дотор хуримтлуулна гэвэл долоо хоногт хэдэн төгрөг хуримтлуулах шаардлагатай вэ?	125 000 төгрөг	$1\ 000\ 000 \div 8$ долоо хоног
3 сарын дотор хуримтлуулна гэвэл долоо хоногт хэдэн төгрөг хуримтлуулах шаардлагатай вэ?	84 000 төгрөг орчим	$1\ 000\ 000 \div 12$ долоо хоног
<b>Шийдвэр</b>	Ганаагийнх 3 сарын дараа хонь худалдаж авахаар шийдэв.	

### Хуримтлалын ач холбогдол юу вэ?

Мал, техник, тоног төхөөрөмж худалдаж авах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, түүхий эдээ боловсруулах нөхцөл бүрдүүлэх нь ирээдүйд ашгаа нэмэгдүүлэх боломж олгох нь ойлгомжтой. Гэвч эдгээрийг хийхийн тулд багагүй мөнгө хэрэгтэй болно. Энд л **хуримтлал** хэрэг болдог.

Малчдад их гарз хохирол учруулдаг байгалийн гамшиг байна, жишээ нь, зуд. 2009-2010 оны өвөл болсон зудны үеэр улсын хэмжээнд 10 шахам сая мал хорогдож, 50 шахам мянган малчин өрх буюу нийт малчин өрхийн 30 гаруй хувь нь мал сүргийнхээ талаас дээш хувийг алдсны дотор 8700 гаруй өрх огт малгүй болж, амьжиргааны эх үүсвэргүй үлдсэн. Зудтай тэмцэхийн тулд зун, намрын дэлгэр цагт хийх ёстой олон ажил байдаг. Жишээ нь:

- отор нүүдэл хийж, малдаа тарга хүч авахуулах, тарга хүчийг нь тогтоох,

- малаа мал эмнэлгийн үзлэгт хамруулах, угаалга, туулгалт хийлгэх,
- хадлан тэжээл бэлтгэх, өвөлжөө, хаваржаандаа татах,
- малд өгөх сувилалын тэжээл бэлтгэх, эм, бэлдмэл нөөцлөх,
- хашаа хороогоо засч, сэлбэх, дулаалах,
- хувийн бэлтгэл хангах (эрүүл мэнд, эрч хүч болон хувцас, хүнс, түлээ...),
- цаг агаарын мэдээ, сэрэмжлүүлэгийг цаг тухайд нь авч байх радио, телевиз, гар утас худалдаж авах, зай тэжээл нөөцлөх,
- эрсдсэн үед нөхөн төлбөр өгдөг сайн дурын даатгалд малаа хамруулах гэх мэт.

Эдгээр зүйлсийг хийж, хэрэгжүүлэхэд мөнгө, **хуримтлал** тус болно.

Хүүхдүүд их, дээд сургуульд суралцах сургалтын төлбөрийн мөнгө. Дахиад **хуримтлал**.

Эрүүл мэндтэй холбоотой, эмчилгээ сувилгааны гэнэтийн зардал гарах нь амьдралд тохиолддог л зүйл. Бүр ихээхэн хэмжээтэй байх нь ч бий. Ийм тохиолдолд **хуримтлал** л аминд орно.



Ганаагийнх хуримтлалаа төлөвлөсөн жишээг харж, өрхийнхөө хуримтлалын төлөвлөгөөг хийгээрэй. Дараах хүснэгтийг ашиглахыг санал болгож байна, харна уу.

..... гэр бүлийн хуримтлалын төлөвлөгөө		
Хуримтлалын зорилго		Тооцоо
<b>Зорилгын өртөг</b>		
1 сарын дотор хуримтлуулна гэвэл долоо хоногт хэдэн төгрөг хуримтлуулах шаардлагатай вэ?		..... ÷ 4 долоо хоног
3 сарын дотор гэвэл?		..... ÷ 12 долоо хоног
6 сарын дотор гэвэл?		..... ÷ 24 долоо хоног
9 сарын дотор гэвэл?		..... ÷ 36 долоо хоног
1 жилийн дотор гэвэл?		..... ÷ 52 долоо хоног
<b>Шийдвэр</b>		



Өнгөрсөн жилийн ашгаа юу юунд зарцуулсанаа, хэрэв энэ мөнгө одоо танд байгаа бол та юунд зарцуулахаа тус тус жагсаан бичээд, хадгалаарай.

**“Санхүүгийн бүртгэл”, “Хуримтлал”** сэдвүүдийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарсан өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Аливаа бараа, түүхий эд, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг мөнгөөр солихыг гүйлгээ гэж нэрлэдэг.			
2. Туслах малчинд цалин өгөх нь гүйлгээ мөн.			
3. Санхүүгийн бүртгэлд гүйлгээ бүрийг бичих шаардлагагүй.			
4. Гүйлгээ бүрийг нэр, хугацаатай нь тодорхой бичих шаардлагатай.			
5. Санхүүгийн бүртгэл хөтлөх нь бүртгэл тооцоог хялбарчилдаг.			
6. Хуримтлал бол Танд бусад хөрөнгөнөөс чинь илүү давуу тал, боломж олгодог онцгой хөрөнгө юм.			
7. Хуримтлалтай болох гэж зорилго тавих хэрэггүй.			
8. Мөнгө хуримтлуулах зорилго, хугацаа тодорхой байх хэрэгтэй.			
9. Хуримтлуулах мөнгөө долоо хоног, сар, жилээр тооцож, түүнийгээ баримтлах нь зөв.			
10. Ашиг олох нь хуримтлал бий болгох нөхцөл мөн.			
11. Би тодорхой зорилгоор хуримтлал бий болгох төлөвлөгөө хийж чадна.			
12. Манай гэр бүл хуримтлалтай болохоор (байгаа хуримтлалаа нэмэгдүүлэхээр) шийдсэн.			

Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариуны Хүснэгт 5-тай тулгаж үзээрэй.

## ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	<b>Хангалтай сайн</b>
2-3 зөрж байвал	<b>Хангалттай</b>
3-аас дээш зөрж байвал	<b>Сэдвээ дахин үзнэ үү</b>

## ЕС. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Санхүүгийн төлөвлөгөө, түүний ач тус, төлөвлөх явц, төлөвлөгөөнд тусгах нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, малын даатгалын зардлын талаар мэдлэгтэй болно.
- Малчин Ганаагийн гэр бүлийн санхүүгийн төлөвлөгөөтэй танилцана.
- Өрхийнхөө санхүүгийн төлөвлөгөөг хийх ялдамд үзсэн зүйлээ бататгах, дасгал хийнэ.

**Санхүүгийн төлөвлөгөө гэж юу вэ?**



Ирээдүйд олох орлого, ашиг, гарах зардлыг тооцож төлөвлөсөн төлөвлөгөөг **санхүүгийн төлөвлөгөө** гэнэ. Санхүүгийн төлөвлөгөөг сар, улирал, жилээр хийж болно.

Бизнес эрхлэхэд ирээдүйгээ тодорхой төсөөлж, тооцоолон санхүүгийн төлөвлөгөө гаргаж, мөрдөж ажиллах явдал зайлшгүй хэрэгтэй байдаг.


Малчин айл ч гэсэн өрхийн аж ахуйн санхүүгийн тодорхой төлөвлөгөөтэй ажиллавал үйл ажиллагаа нь тогтвортой, ашиг орлого нь илүү байх болно.

**Малчин өрхийн санхүүгийн төлөвлөгөөнд юуг тусгах вэ?**



## Санхүүгийн төлөвлөгөөг яаж хийх вэ?

Малчин Ганаагийнх ирэх жилийн санхүүгээ хэрхэн төсөвлөж, тооцоолсон жишээг харъя. Тэднийх ирэх жил нийт **18 916 000** төгрөгийн орлого олж, **17 226 000** төгрөгийн зардал гаргаад, **1 690 000** төгрөгийн ашигтай байхаар төлөвлөгөө хийсэн байна. Доорх зургаас задаргааг харна уу.



**Нийт орлого = 18 916 000, нийт зардал=17 226 000, ашиг=1 690 000**

Одоо орлого, зардлын төрөл бүрийг хэрхэн төлөвлөснийг дараах хүснэгтүүдээс харъя.

Хүснэгт 9.1. Борлуулах мал болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний тооцоо

Борлуулах мал, бүтээгдэхүүн, түүхий эдийн нэр төрөл	Хэмжих нэгж	Борлуулах тоо хэмжээ	Нэгжийг борлуулах үнэ	Орлогын дүн
1	2	3	4	5
хонь	тоо	30	120 000	3 600 000
үхэр	тоо	2	900 000	1 800 000
адуу	тоо	1	600 000	600 000
ямаа	тоо	16	60 000	960 000
ТЭМЭЭ	тоо			

1	2	3	4	5
мах	килограмм	400	4 000	1 600 000
ноолуур	килограмм	36	50 000	1 800 000
хонины ноос	килограмм	400	2 500	1 000 000
цагаан эсгий хийж зарах	метр	20	40 000	800 000
сарлагийн хөөвөр	килограмм	20	18 000	360 000
нэхий	ширхэг	18	12 000	216 000
үхрийн шир	ширхэг	1	30 000	30 000
адууны шир	ширхэг	1	30 000	30 000
сүү	литр	800	800	640 000
ааруул	килограмм	40	6 000	240 000
ээзгий	килограмм	18	10 000	180 000
<b>Мал аж ахуйн борлуулалтын орлогын дүн</b>				<b>13 856 000</b>

Хүснэгт 9.2. Мал аж ахуйн бус түүхий эд, бүтээгдэхүүн борлуулах тооцоо

Борлуулах зүйлийн нэр төрөл	Хэмжих нэгж	Борлуулах тоо хэмжээ	Нэгжийг борлуулах үнэ	Орлогын дүн
Авдар хийж, хээлж зарах	ш	2	100 000	200 000
Чөдөр, ногт зангидаж зарах	хос	8	40 000	320 000
Жимс түүж худалдах	литр	80	5 000	400 000
<b>Мал аж ахуйн бус борлуулалтын орлогын дүн</b>				<b>920 000</b>

Хүснэгт 9.3. Борлуулалтын нийт орлого

Борлуулалтын орлогын төрөл	Борлуулалтын орлогын дүн
Мал аж ахуйн борлуулалтын орлого	13 856 000
Мал аж ахуйн бус борлуулалтын орлого	920 000
<b>Борлуулалтын нийт орлого</b>	<b>14 776 000</b>

Хүснэгт 9.4. Бусад орлогын тооцоо

Орлогын эх үүсвэр	Хэмжих нэгж	Борлуулах тоо хэмжээ	Нэгжийг борлуулах үнэ	Орлогын дүн
бусдад хөлсөөр ажиллах	хоног	15	20 000	300 000
хүүхдийн мөнгө	хүүхэд	3	240 000	720 000
тэтгэвэр	удаа	12	260 000	3 120 000
<b>Бусад орлогын дүн</b>				<b>4 140 000</b>

Хүснэгт 9.5. Өрхийн нийт орлого

Орлогын төрөл	Орлогын дүн
Борлуулалтын нийт орлого	14 776 000
Бусад орлого	4 140 000
<b>Малчин өрхийн нийт орлого</b>	<b>18 916 000</b>

Ганаагийн өрхийн нийт орлого **18 916 000 болж байна.**

Одоо тэдний өрх ирэх жилийн зардлаа тооцоолсон байдалтай танилцъя.

Хүснэгт 9.6. Мал аж ахуй холбоотой зардлын тооцоо

Зардлын зориулалт	Хэмжих нэгж	Худалдаж авах тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авах үнэ	Зарлагын дүн
эм хонь худалдаж авах	тоо толгой	12	130 000	1 560 000
хурга худалдаж авах	тоо толгой	20	45 000	900 000
хивэг худалдаж авах	шуудай	30	12 000	360 000
бензин худалдаж авах	литр	500	1 900	950 000
тариа худалдаж авах	ширхэг	2	25 000	50 000
хашаа хороогоо сэлбэх				1 200 000
<b>Мал аж ахуйтай холбоотой гарах зардлын дүн</b>				<b>5 020000</b>

Хүснэгт 9.7. Өрхийн хэрэглээний зардлын тооцоо

Худалдаж авах барааны нэр	Хэмжих нэгж	Худалдаж авах тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авах үнэ	Зарлагын дүн
1	2	3	4	5
гурил	килограмм	500	1 200	600 000
цагаан будаа	килограмм	60	2 500	150 000
элсэн чихэр	килограмм	40	2 000	80 000
цай	боодол	15	5 000	75 000
ургамлын тос	литр	10	4 000	40 000
хүнсний ногоо	килограмм	80	1 500	120 000
чихэр	килограмм	12	6 500	78 000
жимс	килограмм	48	6 000	288 000
архи	шил	10	14 000	140 000



1	2	3	4	5
тамхи	хайрцаг	100	2000	200 000
гар нүүрний саван	ширхэг	30	1 200	36 000
барааны саван	ширхэг	40	700	28 000
угаалгын нунтаг	боодол	20	4500	90 000
шүдний оо	ширхэг	20	2500	50 000
00-ийн цаас	боодол	40	600	24 000
давс	килограмм	16	500	8 000
лаа	ширхэг	100	100	10 000
шүдэнз	хайрцаг	120	100	12 000
хуруу зай	ш	40	500	20 000
гар чийдэнгийн зай	ш	20	1 500	30 000
газ	баллон	60	1500	90 000
аяга	ш	10	2500	25 000
сав суулга	иж бүрдэл	1	80 000	80 000
ор дэрний хэрэгсэл	иж бүрдэл	2	50 000	100 000
гэрийн гадуур бүрээс	ш	1	50 000	50 000
хувцас авах	том хүн	3	300 000	900 000
хувцас авах	хүүхэд	3	150 000	450 000
гутал авах	том хүн	3	200 000	600 000
гутал авах	хүүхэд	3	120 000	360 000
цагаан сар, улсын баяр, бусад баяр				2500 000
насны ой, хурим (ах, дүү, айл саахалтынх)-ны зардалд				400 000
гэр бүлийн баяр ёслолд				300 000
<b>Өрхийн хэрэглээнд гарах нийт зардал</b>				<b>7 934 000</b>

Тухайн орон нутгийн нөхцлөөс хамаараад малчин өрхийн гэр бүлийн хэрэглээний зүйлс, тэдгээрийн үнэ ханш энд байгаагаас өөр байх магадлалтай.

Өрхийн хэрэглээний зардлын тооцоо бол уг гэр бүлийн хэвшил, зан заншил, хэрэглээ гээд олон зүйлээс хамаарах нь ойлгомжтой. Энэ бүхэн зөвхөн өрхийн хэрэглээний зардал тооцоход төдийгүй бусад зардлын тухайд ч хамаатай болохыг анхаараарай.

Хүснэгт 9.9. Бусдаас ажил, үйлчилгээ авсны төлбөрт төлөх мөнгө

Зардлын зориулалт	Хэмжих нэгж	Худалдаж авах тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авах үнэ	Зарлагын дүн
нүүхэд тээвэр хөлслөх	явалт	8	40 000	320 000
утасны нэгж авах	сард	12	30 000	360 000
БЭБХ* сургалтын төлбөрт	хүн удаа	1	80 000	80 000
хүний эмчилгээ, эмэнд				400 000
сувилалын төлбөрт	хоног	10	35 000	350 000
сур	алд	20	10 000	200 000
банз	ш	6	12 000	72 000
мал эмнэлэгт				200 000
сургуулийн зардалд	сард	9	50 000	450 000
нийгмийн болон эрүүл мэндийн даатгал	хүн	2	322560	645120
малын даатгал				470 960
<b>Ажил, үйлчилгээний хөлсөнд төлөх зардал</b>				<b>3 548 080</b>

**Тайлбар:** БЭБХ- бизнесээ эхэл, бизнесээ хөгжүүл

Ганаагийн гэр бүлийн “Бусдаас ажил, үйлчилгээ авсны төлбөрт төлөх зардал”-д даатгалын зардлууд шинээр нэмэгдсэнийг анзаарч байна уу.

Аливаа даатгал нь эрсдэлээс хамгаалах зорилготой байдаг. Нийгмийн даатгал, малын даатгал ч мөн л эрсдэлээс хамгаална.

Малчин хүн нийгмийн даатгалд хамрагдснаар өөрийнхөө орлогыг буурах, үгүй болохоос хамгаалах боломж бүрддэг. Тухайлбал, нийгмийн даатгалд хамрагдаж, хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж авах болзол хангасан тохиолдолд **өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр, жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж** авч өөрийн орлогоо амьдралын янз бүрийн нөхцөлд хадгалж үлдэнэ.



- Нийгмийн даатгал төлж байх хэрэгтэй гэсэн. Бид хоёр сард хэдэн төгрөг төлөх хэрэгтэй бол, мэдэж авах юмсан...

- Энд их тодорхой байна. Будаад тэмдэглэчихье.



- Нийгмийн даатгалд хамрагдах хүсэлт гаргасан малчин шимтгэл ногдуулах орлогоо өөрөө тодорхойлно.

- Шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ нь тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, байна. Одоо хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192 000 төгрөг байгаа гэвэл шимтгэл ногдуулах сарын орлого хамгийн багадаа 192 000 төгрөг болно.

- Нийгмийн даатгалын сайн дурын даатгал нь 3 төрлийн даатгалыг дотроо агуулдаг. Тухайлбал, **тэтгэврийн даатгал** (төлөх шимтгэл нь 10%), **тэтгэмжийн даатгал** (төлөх шимтгэл нь 1%), **үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгал** (1%), нийтдээ 12 хувиар даатгуулагчийн өөрөө мэдүүлсэн орлогоос шимтгэл тооцно. Жишээлбэл, сарын шимтгэл тооцох орлогоо 192 000 төгрөгөөр мэдүүлсэн бол сард **23 040** ( $192\,000 \cdot 12\% / 100$ ) төгрөг, жилдээ **276 480** төгрөг төлнө.



- Харин эрүүл мэндийн даатгалд шинэ хуулийн дагуу сардаа **3 840** төгрөг, жилдээ **46080** төгрөгийн хураамж төлнө. Товчдоо жилд **322 560** ( $276\,480 + 46\,080$ ) төгрөг төлөөд малчид нийгмийн даатгалд хамрагдаж, ирээдүйнхээ нийгмийн хамгааллын баталгааг хангах боломжтой болно.

Малын даатгал нь малчдын амьжиргааны үндсэн эх үүсвэр болсон мал аж ахуйг эрсдэлээс хамгаалж, өрхийн орлогын тогтвортой байдлыг хангадаг.

Манай улсад малын индексжүүлсэн даатгалын тогтолцоо үйлчилж байгаа. Малчин та сумынхаа малын индексжүүлсэн даатгалын төлөөлөгчтэй уулзаж энэ даатгалын тухай үнэн зөв мэдээллийг авч, малаа даатгуулан эрсдэлээс хамгаалаарай.

Одоо Ганаагийнх ирэх жилд хөрөнгө оруулалтын ямар ямар зардал төлөвлөснийг эргээд харцгаая.

Хүснэгт 9.10. Хөрөнгө оруулалтын зардал

Зардлын зориулалт	Хэмжих нэгж	Худалдаж авах тоо хэмжээ	Нэгжийг худалдаж авах үнэ	Зарлагын дүн
телевизор, антен	иж бүрдэл	1	460 000	460 000
мотоциклийн дугуй авах	ш	2	70 000	140 000
гар утас	ш	2	100 000	200 000
<b>Хөрөнгө оруулалтын зардал</b>				<b>800 000</b>

Хүснэгт 9.11. Нийт зардлын дүн

Зардлын үзүүлэлт	Зардлын нийт дүн
мал аж ахуйн зардал	5 020 000
өрхийн хэрэглээний зардал	7 934 000
ажил, үйлчилгээний хөлс	3 548 080
хөрөнгө оруулалтын зардал	800 000
<b>Малчин өрхийнтухайн жилийн нийт зардал</b>	<b>17 226 000</b>

$$18\ 916\ 000\ \text{₮} - 17\ 302\ 080\ \text{₮} = 1\ 613\ 920\ \text{₮}$$

Ганаагийнх ирэх жил **1 690 000** төгрөгийн ашиг олох тооцоо гарч байна. Хуримтлал ч мөн энэ хэмжээгээр нэмэгдэнэ гэсэн үг.

Хүснэгт 9.12. Ганаагийн гэр бүлийн ирэх жилийн орлого, зарлага, ашгийн нэгдсэн дүн

Үзүүлэлт	Үзүүлэлтийн тоон утга
Мал аж ахуйн борлуулалтын орлого	13 856 000
Мал аж ахуйн бус борлуулалтын орлого	920 000
Бусад орлого	4 140 000
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>18 916 000</b>
мал аж ахуйн зардал	5 020 000
өрхийн хэрэглээний зардал	7 934 000
ажил, үйлчилгээний хөлс	3 548 080
хөрөнгө оруулалтын зардал	800 000
<b>НИЙТ ЗАРДАЛ</b>	<b>17 302 080</b>
<b>АШИГ</b>	<b>1 613 920</b>

### Санхүүгийн төлөвлөгөө ямар ач холбогдолтой вэ?

- Санхүүгийн төлөвлөгөө нь ирэх жилд орох орлого, гарах зардал, олох ашгаа тус тус харах боломжийг олгож байна. (Хүснэгт 9.12.)

- Ашгаа нэмэгдүүлэх болон эрсдэлээс хамгаалахад тус тус чиглэсэн шийдвэрүүдийг үндэслэлтэй гаргах боломжийг олгодог.

Жишээ нь, Ганаагийнх бидний дээр танилцсан төлөвлөгөөг гаргахдаа, орлогоо нэмэгдүүлэхийн тулд авдар хийх, борлуулах малынхаа тоо, сүүний хэмжээг өсгөх зэрэг арга хэмжээ авсан байж болно.

Мөн орлогынхоо тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгалуудад хамрагдах, түүний тулд багагүй хэмжээтэй хураамж, шимтгэл төлөх шийдвэрүүд гаргасан байж болохоор байна.

Дээрх аргачлалаар сар бүрийнхээ санхүүгийн төлөвлөлтийг хийж, түүндээ үндэслэн ирэх жилийнхээ бэлэн мөнгөний орлого, зарлагыг сар бүрээр тооцон гаргаж болно.




Өнгөрсөн жилийнхээ орлого, зардал, ашгийн тооцоог хараад, ирэх жилийнхээ санхүүгийн төлөвлөгөөг яаж хийх талаар тунгаан бодоорой. Дараах зүйлийг сайтар тооцохоо мартуузай. Үүнд:

- Өрхийнхөө орлого, зардал, ашиг, хүн хүчний нөөц бололцоог зөв тооцох,
- Байгалийн гамшиг болон элдэв эрсдэлийг тооцох,
- Эрсдэл тохиолдлоо гэхэд хохиролгүй, бага хохиролтой даван туулах арга зам (өвлийн бэлтгэл, нийгмийн болон бусад даатгал)-ын талаар бодох,
- Мал аж ахуйгаас гадна өөр орлогын эх үүсвэр олох боломжтой эсэх талаар бодох,
- Нутгийн малчдын туршлагыг судлах,
- Танаж болох зардал байгаа эсэхийг өнгөрсөн жилийн зардлын бүртгэл тооцооноосоо харах,
- Олсон ашиг буюу хуримтлалаа хэрхэн зөв зарцуулах гэх мэт.



Гэр бүлийнхээ гишүүдтэй ярилцаад, өрхийнхөө ирэх жилийн санхүүгийн төлөвлөгөөг хийгээрэй. Төлөвлөгөөнийхөө нэгдсэн дүнг доорх бүдүүвчид цэгийн оронд бичээд, малчин Ганаагийнхтай харьцуулж үзээрэй.



## АРАВ. МАЛЧДЫН ХОРШОО

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Малчдын хоршоо, хөдөө аж ахуйн хоршоо, биржийн арилжааны талаар мэдлэг, төсөөлөлтэй болно.
- Малчдын хоршооны талаар төрөөс баримталж буй бодлоготой танилцана.
- Үзсэн зүйлээ бататгах дасгал хийж, өөрийгөө үнэлнэ.

Энэ сэдвийг бид нилээд сайн мэднэ. Яагаад гэвэл бид нутаг, нугынхантайгаа нийлж, хоршоо байгуулан үр шимийг нь хүртэж, ашиг тусыг нь авч байгаа. Хэрвээ Та хоршоонд элссэн, хоршооны талаар сайн мэддэг бол энэ сэдвийг алгассан ч болно.

Харин Та одоогоор малчны хоршоонд элсээгүй, малчны бүлэгт нэгдээгүй байгаа бол хорших, хамтрахын ач холбогдлын талаар санал солилцоцгооё.

### Малчдын хоршоо гэж юу вэ?



Малчдын хоршоо гэдэг нь малын түүхий эдийг хамтран бэлтгэж борлуулах, элдэв бэрхшээлийг хамтарч даван туулах, нийгмийн хариуцлагыг хамтдаа хүлээх, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор тодорхой хөрөнгөөр хувь нийлсэн, гишүүддээ үйлчилдэг малчин өрхүүдийн төлөөллөөс бүрдсэн хуулийн этгээд юм.



- Хуулийн этгээд гэж юу юм бэ?

- Тусгай эд хөрөнгөтэй,
- эрх үүрэгтэй,
- үйл ажиллагаанаасаа үүсэх үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг,
- тодорхой зорилготой,
- тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хэлнэ гэсэн байна, хө.



Ганц нэгээрээ шийдэж хүч хүрэхгүй буюу хүч хүрлээ ч зардал чирэгдэл их, авах олох нь бага болох явдал малчин өрхөд олонтаа тохиолддог. Ийм зүйлсийг хамтарч хийх, харилцан тусалж, хамтран шийдэхийн тулд малчид нэгдэн бүлэг байгуулж, амжилттай ажиллаж байгааг бид эргэн тойрноосоо мэднэ.

Гэхдээ малчдын бүлэг нь аж ахуй зохион байгуулалтын хууль ёсны хэлбэр болж чаддаггүй. Манай улсын хууль тогтоомжоор **компани, хоршоо, нөхөрлөл** л хууль ёсны хэлбэрт тооцогддог.

Аж ахуй зохион байгуулалтын хууль ёсны эдгээр хэлбэр дотроос малчдын хувьд хоршоо л хамгийн тохиромжтой байдаг. Хоршооны ерөнхий зураглалыг дараах зургаас харна уу.



Хоршоо нь малчдад дараах боломжуудыг олгодгийг бид сайн мэднэ. Үүнд:

- зах зээлд нэвтрэх, борлуулалтаа нэмэгдүүлэх,
- борлуулалтын томоохон багц бүрдүүлэх замаар худалдах үнээ өсгөх,
- их хэмжээгээр, бөөнөөр авсанаар худалдан авалтын зардал, үнэ буурах,
- эрсдлээс хамтын хүчин чармайлтаар хамгаалах,
- төрөөс малчдад үзүүлж байгаа санхүүгийн дэмжлэгүүдийг бодитой авах,
- түүхий эддээ боловсруулалт хийх замаар өртөг шингээх,
- өндөр үнэтэй, бүтээмж сайтай техник, тоног төхөөрөмж худалдан авах,
- шинэ бараа, үйлчилгээ бий болгож, зах зээлд гаргах,
- хамтын хүчээр хадлан тэжээл бэлтгэх, худаг ус гаргах,
- түүхий эд бэлтгэх, хадгалах, тээвэрлэх зардлыг хэмнэх зэрэг олон давуу талыг малчдад олгож байгааг эргэн тойрноосоо харж байгаа.

Малчид хоршоонд элсэж, нэгдсэнээр олж авдаг эдгээр боломжуудыг хуульчлан баталгаажуулсан учир байнга тогтвортой байдаг.

Тухайлбал, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуульд, биржийн арилжаанд тусгай зөвшөөрлөөр оролцох, хоршоонд биржээс тусгай

зөвшөөрөл олгох, хоршоо нь анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх гэрээ байгуулж биржийн арилжаанд оролцох тухай тус тус заажээ.

Энэ нь малчин хүн хоршоонд элссэнээр мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнээ өрсөлдөөнөөр ил тод тогтсон, харьцангуй өндөр, тогтвортой үнээр борлуулах боломж бүрдэнэ гэсэн үг юм.

Бирж нь малчин Таны нэгж бүтээгдэхүүний үнийг үндэслэлтэй өсөх, үндэсний үйлдвэрлэл хөгжих боломжийг олгодог талаар “Түүхий эд, бүтээгдэхүүний үнэ” сэдэвт гарч байсныг Та санаж байна уу? Суралцагч Та зөвхөн өөртөө ашиг олох төдийгүй үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, улмаар эх орноо хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах чин хүсэлтэй байдаг биз дээ? Тэгвэл малчны хоршоонд элсэж, биржийн арилжаанд оролцох хэрэгтэй юм байна. Биржийн арилжааны зохион байгуулалтыг доорх зургаас харна уу.



## Малчдын хоршоог дэмжиж хөгжүүлэх талаар төр засгийн бодлогод юу гэж тусгасан байдаг вэ?

Монгол улсыг хөгжүүлэх бодлогын баримт бичгүүдэд Малчдын хоршоог дэмжиж хөгжүүлэх талаар олон заалт оруулж хэрэгжүүлж байна. Тухайлбал:

1. “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг баталсан Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолд “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг Монгол Улсын нэгдсэн төсвийн 3 хувиас багагүй байхаар тооцож жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусгаж, хөрөнгийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа хөдөө аж ахуйн хоршоог түшиглэн хэрэгжүүлэх”,
2. “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай” хуульд, “... нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнд арван сая хүртэл төгрөгийн зээлийг 2 жил хүртэл хугацаагаар олгоно” (12.3.),



3. “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөрт, “хөдөө аж ахуйн гаралтай үйлдвэрлэл, түүхий эд бэлтгэн нийлүүлэх зохион байгуулалтыг хөгжүүлэх нөхөрлөл, хоршоо байгуулахыг дэмжих” (3.2.6.),

4. Улсын Их Хурлын 2012 оны 74 дүгээр тогтоолд, “малаа гарал үүслийн баталгаажуулалтад хамруулсан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд үндэсний боловсруулах үйлдвэрт тушаасан бог малын арьс тутамд 3000 төгрөг, адуу, үхрийн шир тутамд 15000 төгрөгийн урамшуулал олгох”,

5. Улсын Их Хурлын 2011 оны 30, 2015 оны 40 дүгээр тогтоолуудад, “хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдийн бэлтгэж ноос боловсруулах үндэсний үйлдвэрт тушаасан ноосыг малын ашиг шим, үүлдэрлэг байдал, ноосны чанараас хамааруулан 2014 оноос эхлэн хонины ноос, тэмээний ноосны килограмм тутамд 1000-2000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгох” талаар тус тус заасан.

Энэ бүхнээс харахад төрөөс малчдад үзүүлэх дэмжлэг туслалцаа хоршоогоор дамжиж хэрэгжих нь тодорхой харагдаж байна.

Хоршооны тухай болон малчны хоршоог хэрхэн байгуулах тухай асуудлаар сумын “Мал эмнэлэг, үржлийн алба”-ны хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн, үйл ажиллагаа нь жигдэрсэн хоршооныхон, сургагч багш нар хандаж, зөвөлгөө авах нь зүйтэй.



Танай сум, багт байгуулагдаад, амжилттай ажиллаж байгаа хоршооны гишүүдтэй уулзаж, хоршооны ач холбогдлын талаар ярилцана уу.

*Чиглүүлэх асуулт:*

- Хоршоонд элсэх ямар ашигтай вэ?
- Хоршооны хөрөнгийг яаж бүрдүүлдэг вэ?
- Татвар нь их үү?
- Хоршооноос ямар ажил зохион байгуулдаг вэ? гэх мэт

Хоршоонд элсвэл танай өрхийн ашиг, орлогод хэрхэн нөлөөлөхийг бодож үзээрэй.



Хэрэв Та хоршооны гишүүн бол хоршоогоороо дамжуулан ашиг, орлогоо нэмэгдүүлэх талаар шинээр юу хийж болох тухай бодоод, хоршооныхоо бусад гишүүдтэй санал солилцоорой.



Танд ойлгомжгүй, хүндрэлтэй зүйл гарвал багш нар болон сумын мал эмнэлэг, үржлийн албаныханд хандаарай.

**“Санхүүгийн төлөвлөгөө”, “Малчдын хоршоо”** сэдвүүдийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, чадвар, өөртөө болон гэр бүлдээ гарсан өөрчлөлт дэвшлийг үнэлнэ үү.

Зөвшөөрч буй хариуны харгалзах нүдийг будаарай.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Ирээдүйд олох орлого, ашиг, гарах зардлыг тооцож төлөвлөсөн төлөвлөгөөг санхүүгийн төлөвлөгөө гэнэ.			
2. Малчин айлд санхүүгийн төлөвлөгөө хэрэггүй.			
3. Санхүүгийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын зардлыг тусгана.			
4. Аливаа даатгал нь эрсдэлээс хамгаалах зорилготой байдаг. Нийгмийн даатгал, малын даатгал ч мөн л эрсдэлээс хамгаална.			
5. Сарын шимтгэл тооцох орлогоо 192 000 төгрөгөөр мэдүүлсэн бол эрүүл мэндийн даатгалд сард 3 840 төгрөг, жилд 46 080 төгрөгийн хураамж төлнө.			
6. Санхүүгийн төлөвлөгөө нь ирэх жилд орох орлого, гарах зардал, олох ашгаа тус тус урьдчилан харах боломж олгодог.			
7. Малчдын бүлэг, хоршоо хоёрын хооронд ялгаа байхгүй, ижил ойлголт			
8. Малчдын хоршоонд нэгдсэнээр түүхий эд бэлтгэх, хадгалах, тээвэрлэх зардлыг хэмнэнэ.			
9. Малчин хүн хоршоонд элссэнээр мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнээ харьцангуй өндөр, үнээр борлуулах боломж бүрдэнэ.			
10. Манай гэр бүл малчны хоршоонд элссэн.			

Та дээрх хүснэгтэд сонгож будсан хариугаа шалгахдаа энэ номын ард хавсаргасан хариуны Хүснэгт 6-тай тулгаж үзээрэй.

### ҮНЭЛГЭЭ

Бүх хариу таарч байвал	<b>Хангалтай сайн</b>
2-3 зөрж байвал	<b>Хангалттай</b>
3-аас дээш зөрж байвал	<b>Сэдвээ дахин үзнэ үү</b>

## АРВАН НЭГ. ХӨГЖИХ, ДЭВШИХ АРГА ЗАМ

**Зорилго:** Энэхүү сэдвийг судлах явцад Та:

- Бизнес олсон ололт амжилтаа тогтвортой хадгалж, бизнесээ улам өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд юу мэдэх, юуг анхаарах талаар мэдлэг, төсөөлөлтэй болно.
- “Орон нутгийн бизнесийн хөгжил” сургалтын дараа ямар сургалтад хамрагдаж болох тухай мэдээлэл авна.
- Үзсэн зүйлээ бататгах дасгал гүйцэтгэж, өөртөө дүгнэлт хийнэ.

**Бизнес олсон ололт амжилтаа тогтвортой хадгалж, бизнесээ улам өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд бидэнд юу хэрэгтэй вэ?**



Зах зээлийн харилцаатай нийгэмд амьдарч байгаа малчин хүн зөвхөн малаа өсгөж, үржүүлдэг, ашиг шимийг нь авч чаддаг байх нь хангалтгүй. Зах зээлийн арга ухаан, бараа материалын худалдан авалт, бараа материалын нөөцийн хяналт, хүний нөөцийн удирдлага гээд бизнесийн удирдлагын дадлага чадварыг эзэмших хэрэгтэй.



- Бизнесийн удирдлагад суралцахгүй бол яах вэ?

- Эрсдэл, алдагдалд орох магадлалтай. Байнга л суралцах хэрэгтэй юм байна.



Энэ сургалтын дараа өвгөн чинь “Бизнесээ эхэл”, “Бизнесээ хөгжүүл” сургалтад явна аа.

Зах зээлийн харилцаатай нийгэмд амьдарч байгаа малчин хүн зөвхөн малаа өсгөж, үржүүлдэг, ашиг шимийг нь авч чаддаг байх нь хангалтгүй юм. Харин байнга суралцах сурснаа амьдралдаа хэрэгжүүлдэг байхад анхаарах нь чухал. Тухайлбал:

1. *Ашигтай борлуулалт, оновчтой худалдан авалт.* Мал аж ахуйн технологи, арга ухааныг эзэмшиж, ашиглаад бий болгосон мал болон малын гаралтай түүхий эдээ өрсөлдөөнт зах зээлд борлуулж, ахуй амьдралын хэрэгцээт зүйлс, түүнчлэн мал аж ахуйгаа эрхлэхэд шаардлагатай зүйлсийг зах зээлээс худалдаж авах болдог.

Хэрэв та биеийн амрыг харж, сураад ирсэнд нь борлуулаад, хүрээд ирсэнээс нь аваад байвал, хямд зарж, үнэтэй авах болно. Энэ нь борлуулалтын орлогыг чинь бууруулж, зардлыг чинь өсгөх учир, Таны ашиг буурна. Тэгээд зогсохгүй алдагдал хүлээхэд ч хүргэж болно. Цаашлаад өрхийн аж ахуй чинь алдагдалтай байвал танай гэр бүлийн амьдралд нөлөөлж, олж байгаа чинь амь зуулгад тань хүрэхгүй болж мэднэ.



2. *Эрсдэлийн тооцоо, бэлтгэл.* Зөвхөн авах, борлуулахаар зогсохгүй өөр бусад зүйлсийг ч мэддэг, амьдрал дээр ашиглаж чаддаг байх шаардлага зах зээлийн харилцаанд оролцож байгаа хэн бүхний өмнө тулгардаг.

Зах зээлийн харилцаанд оролцож эхэлсэнээр “шатах”, “хулхидуулах”, “мөнгөө түгжих”, “дамбуурах” зэрэг үгс бидний хэрэглээнд орж ирсэн.

Эдгээр нь “ган”, “зуд”, “хүчтэй салхи, шуурга” гэх мэттэй адил зах зээлийн нөхцөлд амьдарч байгаа малчин хүнд тохиолдох эрсдэлүүдийн нэр юм.

“Зуд”-ын эрсдлийг учирсан цагт нь биш урьдчилж хийсэн бэлтгэлээр давах тухай бид “Хуримтлал” сэдэвт ярилцсан.

Зах зээлийн эрсдэлүүдийг мөн адил бэлтгэл сайтай нь л амжилттай давдаг. Энд хийх бэлтгэл нь сурч, хөгжих, бизнесийн арга ухаанд суралцаж, улмаар эзэмшсэн мэдлэг, дадлага чадварууддаа тулгуурлан эрсдлийг урьдчилан харж, түүнээс сэрэмжлэх, хор уршгийг нь бууруулах чадвар эзэмших явдал юм.



3. *Бизнесийн ухаан.* Бид “орлого”, “ашиг”, “нэмүү өртөг”, “хуримтлал” зэрэг үгсийг өргөн хэрэглэж, бусдын тухай ярихдаа “бизнес сэтгэлгээтэй”, “бизнесийн мэдрэмжтэй”, “сайн бизнес эрхлэгч”, “баяжсан”, “цулайсан”, “мөнгөтэй хүн” зэрэг үгсийг ашиглах болсон. Энэ бол бизнес зөвхөн эрсдэл үүрүүлээд байдаггүй, үр ашиг ч өгдөг гэсэн үг.



“Ашиг олох” гэсэн үндсэн зорилго бүхий бизнесийн харилцаанд орж буй өрхийн аж ахуй эрхлэгч малчин хүн ч хөлжих, дэвжихээ бодох ёстой.

Бид ч боддог. Гэхдээ бидний бодол хүсэл, мөрөөдлийн түвшинд үлдэх нь олон байдаг.

Тэгвэл дотроо бодоод, тээгээд явах биш ажил, амьдрал болгож, ахих, дэвших арга замаа хайх ёстой.

Зах зээлийн өрсөлдөөнт харилцаанд ашиг олох зорилгоор оролцохын тулд, өөрөөр хэлбэл, бизнес эрхлэхийн тулд бизнесийн удирдлагын 7 төрлийн дадлага чадварыг эзэмшсэн байх шаардлагатай нь хүн төрөлхтөний ажиглалт, судалгаагаар тогтоогдож, амьдрал, туршлагаар нь батлагджээ.

Бизнесийн удирдлагын эдгээр дадлага чадварыг:

- Зах зээлийн арга ухаан,
- Бараа материалын худалдан авалт,
- Бараа материалын нөөцийн хяналт,

- Өртөг, зардлын тооцоолол,
- Санхүүгийн бүртгэл,
- Санхүүгийн төлөвлөлт,
- Хүний нөөцийн удирдлага гэж тус тус нэрлэдэг.

4. *Сургалт.* Мал маллах арга ухаан, малынхаа ашиг шимийг авах чадварыг малчин хүн өвөг, дээдсээсээ өвлөж, орчин тойрноосоо үлгэр авч эзэмшдэг.



Харин бизнесийн удирдлагын дадлага чадварыг уншиж, бодож, жишээ дасгал хийж, бусдаар заалгаж сурах шаардлагатай байдаг.

Энэ номондоо бид бизнесийн удирдлагын дадлага чадваруудын заримыг авч үзсэн, тухайлбал, санхүүгийн бүртгэл, санхүүгийн төлөвлөлт.


Бизнесийн дадлага чадварыг бүрэн хэмжээгээр эзэмшихийн тулд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Бизнесээ эхэл", "Бизнесээ хөгжүүл" хөтөлбөрийн сургалтанд хамрагдах хэрэгтэй.

Үүний тулд, танай суманд ажиллаж, амьдарч байгаа, тус хөтөлбөрийн сургагч багш нартай холбогдож, сургалтанд сурах хүсэлтэй байгаагаа хэлж, бүртгүүлэн, анкет бөглөх ёстой. Сургагч багш нарын тухай товч мэдээлэл энэ номын төгсгөлд байгаа.

Түүнчлэн хоршоонд элсэх, нэгдэх, хоршоог зөвхөн зарим нэг түүхий эдийн нөхөн олговор олж авах зэрэгт ашиглах төдий биш, харин ашиг орлогоо нэмэгдүүлэх, аж ахуйгаа хөгжүүлэх арга хэрэгсэл болгох талаар бодож, зөвлөлдөх хэрэгтэй.



Дараах бүдүүвч дэх цэгийн оронд тохирох санааг гүйцээж бичээрэй.



Та өөрийнхөө бизнесийн дадлага чадвар эзэмшсэн байдлаа үнэлж, дүгнэж үзээд, дүгнэлтэндээ үндэслэн өөрийнхөө сурч мэдэх хэрэгцээ, шаардлагатай байгаа зүйлсийг жагсаан бичнэ үү.



Та хоршоонд элсч, нэгдсэн бол боломжоо хэрхэн ашиглаж байгаадаа дүгнэлт хийнэ үү. Нийлж хийж, шийдсэнээр ашиг орлогыг тань нэмэгдүүлж болох зүйлсийн талаар болон хоршооны боломжийг бүрэн ашиглах талаар хоршооныхоо гишүүдтэй ярилцана уу.

## ӨӨРИЙГӨӨ ҮНЭЛЭХ АСУУЛГЫН ХАРИУ

### ХҮСНЭГТ 1. “БИЗНЕС” сэдвээр өөрийгөө үнэлэх асуулгын хариу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Бусдад хэрэгцээтэй бараа, түүхий эдийг нь нийлүүлэн орлого, ашиг олох, санхүүгийн байдлаа сайжруулах, хуримтлал бий болгохыг бизнес гэнэ.			
2. Бизнесээс орлого, ашиг олж л байвал бусдын сэтгэл ханамж чухал биш.			
3. Ур чадвар, нөөц, хэрэгцээ бол бизнесийн санааг сонгох үндсэн шалгуур үзүүлэлт юм.			
4. Бизнесийн санааны найдвартай эсэхийг тогтоохын тулд тусгай аргаар шинжилгээ хийнэ.			
5. Бизнесийн санааны сул тал ба аюул нь илүү байвал түүнийг хэрэгжүүлж болно.			
6. Өрсөлдөөн бол зах зээлийн нийгмийн хөдөлгөгч хүч юм.			
7. Бизнес эрхлэхийн тулд заавал сургалтад суух шаардлагагүй.			
8. Нөөцийн бүртгэл хөтлөх, өртөг зардлаа тооцох, орлого, зарлагаа бүртгэх, ашиг, хуримтлалаа тооцох, ирээдүйн орлого, зарлагаа тооцож, төлөвлөх зэрэг бизнесийн чадвар, дадлыг эзэмшихийн тулд сургалтад хамрагдаж суралцах ёстой.			
9. Бизнесээ эхлэхийн тулд эхлээд “аз турших” хэрэгтэй. Бодож тооцож, цаг алдах хэрэггүй.			
10. Арилжаа наймаа худалдан авах тал болон борлуулах талын итгэл, харилцан итгэлцэл дээр явагдана.			
11. Би (манай гэр бүл) найдвартай бизнесийн санаа олж, түүндээ шинжилгээ хийсэн.			
12. Бизнесээ амжилттай эрхлэхийн тулд сургалтад явахаар шийдсэн.			

### ХҮСНЭГТ 2. “ЗАРДАЛ” сэдвээр өөрийгөө үнэлэх асуулгын хариу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Худалдан авалт, ажил үйлчилгээ, сургалт зэргийн үнэ, хөлсөнд төлж байгаа мөнгөн зарлагыг зардал гэнэ.			
2. Бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн зардлыг бууруулах, тогтвортой байлгахад зардлын бүртгэл тооцоо ач холбогдолтой.			
3. Бараа бүтээгдэхүүний үнийг тогтооход зардлын тооцоо хэрэггүй.			
4. Санхүүгийн төлөвлөгөөг зардлын бүртгэл тооцоонд үндэслэн боловсруулна.			
5. Бизнес эрхлээд олсон нийт орлого бол ашиг мөн.			
6. Малчин өрхийн нийт орлогыг борлуулалтын орлого, бусад орлого гэж 2 ангилж болно.			

Үргэлжлэл нь ард бий

## ХҮСНЭГТ 2-ын үргэлжлэл

7. Борлуулалтын болон бусад орлогоо нэмэгдүүлбэл ашиг нэмэгдэнэ.			
8. Өрхийн зардлыг бүртгэхдээ тухайн өрхөөс гарч байгаа гол гол мөнгөн зарлагыг бүртгэнэ гэсэн үг.			
9. Гэр ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар техник хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж, цахилгаан үүсгүүр худалдаж авахад зарцуулсан ихээхэн хэмжээний зардлыг хөрөнгө оруулалтын зардал гэдэг.			
10. Ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд зардлаа бүртгэж, тооцоод байх шаардлагагүй.			
11. Зардлаа бүртгэж тооцохгүй бол ашиг орлогоо нэмэгдүүлэх боломжоо алддаг.			
12. Манай гэр бүл өрхийн зардлаа бүртгэж тооцож байхаар шийдсэн.			

## ХҮСНЭГТ 3. “ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ” сэдвээр өөрийгөө үнэлэх асуулгын хариу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Худалдан авалт, ажил үйлчилгээ, сургалт зэргийн үнэ, хөлсөнд төлж байгаа мөнгөн зарлагыг зардал гэнэ.			
2. Зардал + ашиг нь худалдан авсан болно.			
3. Бараа бүтээгдэхүүний чанарыг сайжруулах нь зардлыг нэмэгдүүлж үнийг бууруулна.			
4. Борлуулалтын багцад хүрсэн хэмжээний түүхий эд, бүтээгдэхүүний нэгжийн үнэ хамгийн өндөр байдаг.			
5. Борлуулалтын багц бүрдүүлснээр тээвэрлэлт, борлуулалтын зардал нэмэгддэг.			
6. Малчдын хоршоонд элсвэл мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээ борлуулах илүү сайн боломжийг бүрдүүлнэ.			
7. Түүхий эдийн бирж нь зах зээлд нэвтрэх боломжийг нэмэгдүүлэх, бодит үнэ тогтоох, ил тод байдлыг хангах, бизнесийн үйл ажиллагааны зардлыг бууруулах гэх зэрэг олон ач холбогдолтой.			
8. Бусдад бүтээгдэхүүнээ худалдах үнийг борлуулах үнэ, бусдаас худалдан авсан үнийг худалдаж авсан үнэ гэдэг.			
9. Түүхий эд, бүтээгдэхүүний үнийг үндэслэлтэй өсгөвөл, өрсөлдөөнөөс хасагдаж, зах зээлээс шахагдана.			
10. Түүхий эд, бүтээгдэхүүний үнийг үндэслэлтэй өсгөвөл, өрсөлдөх чадвараа хадгалж, илүү ашиг олно.			
11. Борлуулах үнэнээс худалдаж авсан үнийг хассан зөрөөг нэмэгдсэн өртөг гэж нэрлэдэг.			
12. Манай гэр бүл малчдын хоршоонд элсэхгүй. Ямар ч ашиггүй гэсэн.			

**ХҮСНЭГТ 4. “ОРЛОГО, АШИГ” сэдвүүдээр өөрийгөө үнэлэх асуулгын хариу.**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Борлуулсан тоо, хэмжээг борлуусан үнээр үржүүлсэнийг борлуулалтын орлого гэнэ.			
2. Нийт орлого дээр нийт зардлаа нэмсэнийг ашиг гэнэ.			
3. Орлогыг борлуулалтын орлого, бусад орлого гэж 2 ангилдаг.			
4. Борлуулах түүхий эд, бүтээгдэхүүний тоо, хэмжээг нэмэгдүүлбэл орлого буурна.			
5. Борлуулах зүйлийнхээ тоо, хэмжээг нэмэгдүүлбэл орлого нэмэгдэнэ.			
6. Ашгийн тоон утга хасах тэмдэгтэй тоо гарвал ашигтай байна гэсэн үг.			
7. Ашгийн тоон утга нэмэх тэмдэгтэй тоо гарвал ашигтай байна гэсэн үг.			
8. Борлуулалтын багц бүрдүүлснээр ашиг нэмэгдэхгүй, харин ч зардал нэмэгдэнэ.			
9. Малчин өрхийн орлого улирлын чанартай жилийн сар, улирал бүрт жигд бус байдаг.			
10. Ашиг, алдагдлаа зохицуулах гэж илүү ажил болсоны хэрэггүй. Олсон хэдийгээ хэзээ, яаж зарцуулах нь угаасаа тодорхой юм чинь.			
11. Ашиг, алдагдлаа бодож зохицуулах хэрэгтэй. Орлого багатай саруудад алдагдал хүлээхгүй байхад бэлэн байх ёстой.			
12. Манай гэр бүл орлого, зардал, ашгаа бүртгэж, тооцоолж байхаар шийдсэн.			

**ХҮСНЭГТ 5. “САНХҮҮГИЙН БҮРТГЭЛ”, “ХУРИМТЛАЛ” сэдвүүдээр өөрийгөө үнэлэх асуултын хариу.**

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Аливаа бараа, түүхий эд, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг мөнгөөр солихыг гүйлгээ гэж нэрлэдэг.			
2. Туслах малчинд цалин өгөх нь гүйлгээ мөн.			
3. Санхүүгийн бүртгэлд гүйлгээ бүрийг бичих шаардлагагүй.			
4. Гүйлгээ бүрийг нэр, хугацаатай нь тодорхой бичих шаардлагатай.			
5. Санхүүгийн бүртгэл хөтлөх нь бүртгэл тооцоог хялбарчилдаг.			
6. Хуримтлал бол Танд бусад хөрөнгөнөөс чинь илүү давуу тал, боломж олгодог онцгой хөрөнгө юм.			
7. Хуримтлалтай болох гэж зорилго тавих хэрэггүй.			
8. Мөнгө хуримтлуулах зорилго, хугацаа тодорхой байх хэрэгтэй.			
9. Хуримтлуулах мөнгөө долоо хоног, сар, жилээр тооцож, түүнийгээ баримтлах нь зөв.			
10. Ашиг олох нь хуримтлал бий болгох нөхцөл мөн.			
11. Би тодорхой зорилгоор хуримтлал бий болгох төлөвлөгөө хийж чадна.			
12. Манай гэр бүл хуримтлалтай болохоор (байгаа хуримтлалаа нэмэгдүүлэхээр) шийдсэн.			



**ХҮСНЭГТ 6. “САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ”, “МАЛЧДЫН ХОРШОО”** сэдвүүдээр өөрийгөө үнэлэх асуултын хариу.

	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Ирээдүйд олох орлого, ашиг, гарах зардлыг тооцож төлөвлөсөн төлөвлөгөөг санхүүгийн төлөвлөгөө гэнэ.			
2. Малчин айлд санхүүгийн төлөвлөгөө хэрэггүй.			
3. Санхүүгийн төлөвлөгөөнд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын зардлыг тусгана.			
4. Аливаа даатгал нь эрсдэлээс хамгаалах зорилготой байдаг. Нийгмийн даатгал, малын даатгал ч мөн л эрсдэлээс хамгаална.			
5. Сарын шимтгэл тооцох орлогоо 192 000 төгрөгөөр мэдүүлсэн бол эрүүл мэндийн даатгалд сард 3 840 төгрөг, жилд 46 080 төгрөгийн хураамж төлнө.			
6. Санхүүгийн төлөвлөгөө нь ирэх жилд орох орлого, гарах зардал, олох ашгаа тус тус урьдчилан харах боломж олгодог.			
7. Малчдын бүлэг, хоршоо хоёрын хооронд ялгаа байхгүй, ижил ойлголт			
8. Малчдын хоршоонд нэгдсэнээр түүхий эд бэлтгэх, хадгалах, тээвэрлэх зардлыг хэмнэнэ.			
9. Малчин хүн хоршоонд элссэнээр мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнээ харьцангуй өндөр, үнээр борлуулах боломж бүрдэнэ.			
10. Манай гэр бүл малчны хоршоонд элссэн.			

**Ашигласан материал**

1. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Бизнесээ эхэл”, “Бизнесээ хөгжүүл” хөтөлбөрийн сургалтын материал
2. Гүндэгмаа Д., XXI зууны малчин багц модуль, УБ., 2010
3. Оюун Л. Нар, Санхүүгийн хөтөч, иргэдэд зориулсан гарын авлага, УБ., 2010
4. Энхтунгалаг Б., Малчин өрхийн аж ахуйн бизнес орчин, түүнийг сайжруулах зарим арга зам, УБ., 2013

**Сургагч багш нарын бүртгэл**

д/д	Овог нэр	Эрхэлдэг ажил	Утас
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			

ОЛОН УЛСЫН  
ХӨДӨЛМӨРИЙН  
БАЙГУУЛЛАГА

НҮБ-ын байр, Өрөө 209  
Нэгдсэн үндэстний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201  
Монгол Улс

Утас: 976 11 320624

Факс: 976 11 320625

<http://www.ilo.org>